

# MAGNETAR 9000

## ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА



- ГҮНИЙ АЛТ
- ЖИЖИГ АЛТ
- ЭРДЭСТЭЙ ГАЗАР



**Nokta**  
DETECTION TECHNOLOGIES



## ТӨХӨӨРӨМЖИЙГ АШИГЛАХЫН ӨМНӨ АНХААРАЛТАЙ УНШИНА УУ!

### ХУУЛИЙН МЭДЭГДЭЛ

Хайгчийг ашиглахдаа тухайн бүс нутагт мөрдөж буй хууль тогтоомжийг дагаж мөрдөнө үү. Археологийн дүрсгалт газар, түүхэн балгас, цэргийн бүсэд бүү ашиглаарай. Түүх, соёлын олдворуудын талаар холбогдох байгууллагад ямагт мэдээлнэ үү..

### АНХААРУУЛГА

МАГНЕТАР 9000 бол хамгийн сүүлийн үеийн технологиор үйлдвэрлэсэн дэвшилтэт цахим хайгч юм. Хэрэглэгчийн гарын авлагыг уншаагүй бол төхөөрөмжийг угсрах эсвэл ашиглахыг хориглоно.

Металл Хайгч болон тавгийг хэт хүйтэн эсвэл халуун орчинд удаан хугацаагаар байлгаж болохгүй. (Хадгалах температур: - 20°C (-4°F)-аас +60°C (+140°F).

Энэхүү төхөөрөмж Р68 стандартын дагуу 3 м (10фут) хүртэл гүнд үс нэвтэрдэггүй байхаар бүтээгдсэн. Bluetooth® чихэвч энэ хамгаалалтад ороогүй болно.

Хайгчийг ялангуяа хужир, давстай усанд хэрэглэсний дараа дараах зүйлийг анхаарна үү:

1. Төв аппарат, иш, тавагны холболтыг цэвэр усаар зайлж, холбогч хэсгүүд дээр үс үлдсэн эсэхийг шалгаж бай..
2. Цэвэрлэхдээ химийн бодис хэрэглэж болохгүй.
3. Угаасны дараа Төв аппарат, иш болон дэлгэцийг зөөлөн, хуурай даавуугаар арчиж хатаана.

Ашиглалтын явцад хайгчаа цохилтоос хамгаал. Тээвэрлэлтийн үед төхөөрөмжийг анхны хайрцагт нь хийж, чичиргээнд тэсвэртэй сав баглаа боодлын материалаар жийргэлж байна үү.

MAGNETAR 9000-г зөвхөн эрх бүхий Nokta үйлчилгээний төвөөр засварлуулж болно. Төхөөрөмжийг ямар нэгэн шалтгаанаар задалсан бол баталгаат засвар хүчингүй болно.

АНХААР! Хайгчийг зөвхөн задгай талбайд ашиглана. Байшин, барилга гэх мэт их хэжээний металл орчинтой газар дохио тасалдах явдал гарч болзошгүй.

Хайгчаа бусад хайгч эсвэл соронзон долгион ялгаруулдаг төхөөрөмжөөс 10 м дотор ашиглаж болохгүй, хөндлөнгийн шууд нөлөө үүснэ. Хайгчаа ашиглаж байхдаа биедээ металл эд зүйл авч явахгүй байх хэрэгтэй. Алхаж байхдаа төхөөрөмжийг гуталнаасаа хол байлга, учир нь таны бие, гутлын металл эд зүйлийг бай хэмээн дуугарах болно.

АНХААР! Таны хайгч хайлт хийж байх явцад гар утас гэх мэт цахилгаан соронзон долгион ялгаруулдаг зүйлсийг бай болгон хуурамч дохио үүсгэн дуугарч болзошгүй.

## ГАРЧИГ

|                                   |         |
|-----------------------------------|---------|
| УГСРАЛТ _____                     | : 3-8   |
| ЦҮНХИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ         |         |
| ҮҮРГЭВЧ _____                     | : 6-8   |
| БАГЦЫН АГУУЛГА _____              | : 9-10  |
| ТӨХӨӨРӨМЖИЙН ЕРӨНХИЙ              |         |
| ТОЙМ _____                        | : 11-12 |
| ДЭЛГЭЦИЙН ТОЙМ _____              | 13      |
| НАРИЙН /ЭКСПЕРТ/ ТОХИРГОО _____   | 13      |
| ХЯЛБАР ТОХИРГОО _____             | 14      |
| ЗАЙНЫ МЭДЭЭЛЭЛ _____              | : 15-16 |
| ЗӨВ ХЭРЭГЛЭЭ _____                | 17      |
| ХУРДАН ЭХЛЭХ _____                | : 18-19 |
| НАРИЙН ТОХИРГОО БА                |         |
| ТОХИРГООНЫ ЦЭС _____              | : 19-20 |
| ГОРИМУУД MODE _____               | : 20-21 |
| ХЭРЭГЛЭГЧИЙН ТОХИРГОО /САН/ _____ | : 21-22 |
| ХӨРС _____                        | 23      |
| ШУУГИАНЫГ ДАРАХ _____             | : 24-25 |
| ГАЗАР ТЭНЦВЭРЖҮҮЛЭГЧ _____        | : 25-27 |
| МЭДРЭМЖ _____                     | 27      |
| ДУУНЫ ТОХИРГОО _____              | 28      |
| СУУРЬ /БОСГО/ ДУУНЫ ХЭМЖЭЭ _____  | 28      |
| СУУРЬ ДУУНЫ ҮЕЛЗЭЛ _____          | 29      |
| ДУУНЫ ШҮҮЛТҮҮР _____              | : 29-30 |
| ТЭНЦВЭРЖҮҮЛЭГЧ _____              | 30      |
| БАЙНЫ ДУУНЫ ТҮВШИН _____          | 31      |
| ТОХИРГООНЫ ЦЭС _____              | : 31-39 |
| 1. Арын гэрэл _____               | : 32-33 |
| 2. Блютуз® _____                  | : 33-35 |
| 3. Цэсийн өнгө _____              | 35      |
| 4. Хэл _____                      | 35      |
| 5. Товчлуурын дуу _____           | 36      |
| 6. Товчлуурын чичиргээ _____      | 36      |
| 7. Товчлуурын гэрэл _____         | 37      |
| 8. Чийдэн _____                   | 37      |
| 9. Төхөөрөмжийн мэдээлэл _____    | 38      |
| 10. Үйлдвэрийн тохиргоо _____     | : 38-39 |

**ГАРЧИГ (үргэлжлэл)**

|                                         |         |
|-----------------------------------------|---------|
| ШИНЭЧЛЭХ (ПРОГРАММЧЛАХ) ГОРИМ _____     | 39      |
| АЛДААНЫ КОД _____                       | 39      |
| АНХААРУУЛГА МЕССЕЖ _____                | 39      |
| СЭРГЭЭХ _____                           | 40      |
| ЧИХЭВЧНИЙ МЭДЭЭЛЭЛ _____                | 40      |
| ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД _____             | : 41-42 |
| *СЭРГЭЭХ:                               |         |
| (Системийг анхны хэвэнд оруулах үйлдэл) |         |

## УГСРАЛТ

- (1) Доод ишний үүрэнд тавагны резин жийргэвчийг байрлуулсны дараа доод ишийг хайлтын таваг руу суулгана. Боолтоор доод ишийг хайлтын тавагт бэхлээрэй. Хэт чангалахаас болгоомжил.
- (2) Дунд ишийг доод болон дээд иштэй холбохын тулд ишний түгжээг нээж, ишийг бие бие рүү нь гулсуулж оруулна. Дараа нь хайгчийн уртыг өөрийн өндөрт тааруулан тохируулж, хажуугийн боолтоор чангалж, ишний түгжээг хаана.
- (3) Хайлтын тавагны кабелийг зурагт (Зураг А) үзүүлсний дагуу хэт чанга татахгүйгээр ишийг тойруулан ороож эвхэнэ. (Figure A).



Зураг А

Дараа нь холбогчийг зурагт (Зураг В) үзүүлсний дагуу төхөөрөмж дээрх хайлтын тавагны оролт руу хийж, боолтыг чангалж бэхлэнэ. Чангалах үед "товших" (click) чимээ сонсогдож магадгүй. Энэ нь холбогч бүрэн түгжигдсэнийг илтгэнэ..

Зураг В:



**АНХААР!** Хайлтын тавагны кабелийн холбогчийг төхөөрөмж дээрх тавагны оролттой тааруулж оруулна. Холбогч нь зөвхөн нэг чиглэлд орохоор зохион байгуулагдсан байдаг. Холболтын зүүг гэмтээхгүйн тулд холбогчийг хүчээр шахаж болохгүй, дотор талын чиглүүлэгч ховил нь үүртэйгээ яг таарч байгаа эсэхийг шалгаарай. Яг таарсны дараа боолтыг чангалж бэхлэнэ.



(4) Дээд ишнийдоод хэсэгт байрлах кабель чиглүүлэгч үүрийг ашиглан кабелийг бэхлээрэй. (Зураг С).

Зураг С:



(5) MAGNETAR 9000-ын зайг урд талын текст нь уншигдахуйц чиглэлтэйгээр барьж, зурагт (Зураг D) үзүүлсний дагуу үүрэнд байрлуулна. Зайг үүр рүү тултал нь шахсаны дараа зурагт (Зураг E) үзүүлсний дагуу баруун, зүүн талын түгжээнүүдийг ашиглан бэхэлгээг гүйцээнэ үү..



Зураг D:

Зураг E:



(6) Тохойн тулгуурыг тааруулахын тулд түгжээг нээж хүссэн хэмжээндээ хүргэж, бэхлэхийн тулд түгжээг зураг F-т үзүүлсний дагуу хаана.

Зураг F:



(7) Тохойн тулгуурын оосрыг зурагт (Зураг G) үзүүлсний дагуу бэхэлж, өөрийн гарны хэмжээнд тааруулан чангална.

Зураг G:



(8) Төхөөрөмжид дагалдаж ирсэн хуванцар бөгжийг (ferrite ring) наалддаг туузны (hook & loop tape) тусламжтайгаар зурагт (Зураг H) үзүүлсний дагуу хайгчид бэхэлнэ.

Зураг H:



АНХААР! Чихэвч болон программ шинэчлэлийн портыг ашиглах үедээ зурагт үзүүлсний дагуу тоосны хамгаалалтын (Зураг I), тагийг ашиглаарай

Зураг I:



АНХААР! Ишний ар талын цагаан шугамууд нь ишийг сунгаж болох хамгийн дээд уртыг заана. Энэ хязгаараас хэтрүүлж болохгүй.



## ҮҮРГЭВЧИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ

1. Үүргэвчийг нуруундаа үүрнэ. Зурагт үзүүлсний дагуу баруун, зүүн талын оосрыг ашиглан бүсэлхийн бүсийг тааруулж чангалаад, бүсний тэвхийг түгжинэ. "Товших" чимээ сонсогдоно. Бүс таны бүсэлхийгээр яг таарч суухын тулд баруун, зүүн оосрын үзүүрийг урагш татна.



АНХААР! Татлагын тулгуур саваа /bungee stick/-г ашиглахад бүсийг биедээ зөв тааруулах нь нэн чухал. Бүсийг бэхэлсний дараа дараагийн алхамуудыг гүйцэтгэнэ.

2. Цээжний оосрын тэвхийг зурагт үзүүлсний дагуу түгжинэ. "Товших" чимээ сонсогдоно.



Зурагт үзүүлсний дагуу чиглүүлэгчийг зүүн тийш татаж оосрын чанга сулыг тааруулна...



3. Үүргэвчний хоёр талын бэхэлгээг дээш, доош хөдөлгөх замаар цээжний оосрыг өөрийн цээжний түвшинд тааруулна. Ингэснээр илүү тухтай ашиглах зайг тохируулах боломжтой болно.



4. Үүргэвчийг нуруундаа зөв байрлуулахын тулд цээжний оосорноос унжиж буй татлагуудыг ашиглана уу.

АНХААР! Хэрэв танд үүргэвчний оронд ашиглах боломжтой тусгай хантааз байгаа бол хантаазан дээр мөн эдгээр аргыг хэрглэнэ.

## ХИПСТИК & БАНЖИ ТАТЛАГЫГ УГСРАХ

АНХААР! Татлагын тулгуур иш /саваа/ нь таны бүсэлхий болон цээжний хоорондох холболтыг хангаж, банжи (татуурга оосор)-г бэхлэх боломжийг

1. Бөмбөлөг хэлбэртэй хуванцар үүрийг (socket) бүсэлхийн бүсний баруун талд, үүрний нээлхийг дээш харуулан зурагт үзүүлсний дагуу бэхэлнэ..





2. Татлагын тулгуур ишний уртыг тохируулахын тулд иш дээрх хуванцар түгжээг сугалж авна. Зурагт үзүүлсний дагуу дуран хэлбэртэй сүнадаг гуурснуудыг уртасгах эсвэл богиносгох замаар өндрийг тааруулж, хоёр гуурсны нүхнүүдийг хооронд нь тааруулна. Нүхнүүд таарсны дараа сугалж авсан хуванцар хэсгийн зүү (pin)-ийг нүхнүүдээр нэвтрүүлж хийнэ. Зүү түгжигдэх үед "товших" чимээ сонсогдоно.



3. Татлагын тулгуур иш (саваа)-ний доод талд байрлах бөмбөлгийг бүсэлхийн бүсний баруун талд суулгасан хуванцар үүрэнд зурагт үзүүлсний дагуу бэхлэнэ. Бүрэн түгжигдэх үед товших чимээ сонсогдоно.



4. Татлагын тулгуур ишний дээд талын дэгээг үүргэвчний мөрний түвшинд байгаа 3 нүхний аль нэгнээр шургуулж зурагт үзүүлсний дагуу өөрийн биед тохирох өндрийг сонгон бэхэлнэ.



### Татуурга оосрыг үгсрах (bungee cord)

1. Наалддаг туузыг зурагт үзүүлсний дагуу дэгээний амсрыг нь гадагш харуулан төхөөрөмжийн доод ишэнд бэхлэнэ.



2. Татуурга оосорны нүхийг зурагт үзүүлсний дагуу доод ишинд бэхэлсэн наалддаг туузын дэгээгээр сүвлэж оруулна.



АНХААР! Татуурга оосрыг төхөөрөмжийн доод ишинд бэхлэх нь ашиглахад хамгийн тохиромжтой, зөвлөмж болгож буй арга юм.

3. Татуурга оосрны нөгөө үзүүрт байрлах дэгээг үүргэвчний мөрний түвшинд байгаа тулгуур ишний нүхээр зурагт үзүүлсний дагуу сүвлэж оруулна. Энэ үед дэгээн дээрх NOKTA лого тань руу харсан байх ёстой.



АНХААР! Дэгээн дээрх NOKTA лого тань руу харсан байх нь татуурга оосор зөв түгжигдсэн байх маш чухал тэмдэг юм.



4. Төхөөрөмж таны хүссэн өндөрт тэнцвэртэй байх хүртэл bungee cord (татуурга оосор)-ыг доош нь дарж, татах замаар түгжинэ. Оосрыг түгжээнээс гаргахын тулд дээш нь татна.



АНХААР! Тохойн тулгуур оосрыг өөрийн гарны өргөнд тохируулан засаарай. Ингэснээр хайгчийг Хялбархан хөдөлгөх удирдах боломжтой болно.

5. Хайлтын талбайд бай илэрч, хөрс ухах шаардлагатай үед татуурга оосрыг үүргэвчнээс салгах хэрэгтэй. Цээжний түвшинд байгаа тулгуур ишний нүхнээс оосрын түгжээг мултан авч, төхөөрөмжийн armrest (тохойн тулгуур)-ын хэсэгт бэхлээд, төхөөрөмжийг газарт тавьж болно.

АНХААР! Үүргэвчний зүүн эсвэл баруун талын аль алинд нь тохируулан ашиглаж болно. Энэхүү зааварт баруун гартай хэрэглэгчдэд зориулсан алхмуудыг харуулав. Хэрэв та солгой гартай бол эдгээр алхмуудыг үүргэвчний зүүн талд ижил дарааллаар хэрэгжүүлээрэй.

АНХААР! Энэ аргууд нь төхөөрөмжийг авч явахад хялбар болгож, хайгуул хийх үеийн хөдөлгөөнийг хөнгөвчилдөг.

## БАГЦЫН ДАГАЛДАХ ЭД АНГИУД

Усны хамгаалалттай DRC хайлтын таваг, хамгаалалтын гэр (Хэмжээ: 37 см х 34 см)



MG29-DRC загварын хайлтын таваг (Хэмжээ: 29 см х 21 см)



Nokta брэндийн Bluetooth® утасгүй чихэвч болон цэнэглэгч кабель



6.3 мм-ийн чихэвчний шилжүүлэгч кабель



2 ширхэг Лити-ион зай



Цэнэглэгч болон олон улсын стандартын шилжүүлэгч хошуунууд

Авто машины цэнэглэгч



Автомашины зайнаас цэнэглэх хавчаартай кабель



## БАГЦЫН ДАГАЛДАХ ЭД АНГИУД

Хайгчийн үүргэвч



USB өгөгдлийн бабель



Феррит шар бөгж




Хипстик & Банжи Тулгуур иш & татлага оосор



Nokta стандартын хөрс ухагч утгуур болон гэр





## ХАЙГЧИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

### 1. LCD дэлгэц

### 2. Асаах/унтраах товчлуур

Төхөөрөмжийг асаахын тулд ойролцоогоор 1 секундын турш удаан дарна. Унтраахын тулд товчийг ойролцоогоор 3 секундын турш удаан дарна.

### 3. Сонгох товчлуур

Эксперт цэснээс тохиргооны цэс рүү шилжих болон тодорхой үйлдэлд хийсэн өөрчлөлтийг баталгаажуулахад ашиглана. Энэ нь тодорхой шинжүүдэд өөр өөр үүрэгтэй, холбогдох хэсгүүдэд дэлгэрэнгүй тайлбарласныг үзнэ үү.

### 4. Баруун, зүүн шилжүүлэх товчлуур

Мэргэжлийн цэс эсвэл тохиргооны цэсээр дамжуулан шилжилт /навигаци/ хийхэд ашиглана.

### 5. Дээш, доош шилжүүлэх товчлуур

Мэргэжлийн цэс эсвэл тохиргооны цэснээс сонгосон үйлдлийг дэд сонголтоор урагш, хойш гүйлгэх зорилгоор ашигладаг. Зарим тохиолдолд сонгосон үйлдлийн утгыг нэмэх эсвэл бууруулахад ашиглана; дээш эсвэл доош навигацийн товчлуурыг дарах бүрт үйлдлийн утга (жишээ нь: мэдрэгч чанар, дууны түвшин)-ыг нэг шатаар нэмж тохируулдаг.

### 6. Хэрэглэгчийн хувийн тохиргоо /сан профайл/

Төхөөрөмж дээр байнга ашигладаг хайлтын тохиргоогоо хадгалах, хадгалагдсан тохиргоонд хурдан эргэж орох боломжийг танд олгоно. Хялбар цэс /Easy Menu/ -нд байхдаа та профайл товчийг дарж Мэргэжлийн цэс /Expert Menu / рүү хурдан шилжиж болно.

### 7. Буцах товчлуур

Дээд түвшний цэс рүү буцахад ашиглагддаг. Тохиргооны цэсэнд байх үед буцах товчийг дарахад төхөөрөмжийг Мэргэжлийн цэс рүү буцаана.



### 8. Арын Гэрэл

### 9. Газар тэнцвэржүүлэгч /гох/ товч

Энэ товч нь танд MAGNETAR 9000 дээр хэмжээнд газар тэнцвэржүүлэлтийг автоматаар тохируулах боломжийг олгоно. Дэлгэрэнгүй мэдээллийг 25-27 хуудаснаас үзнэ үү.

**ХАЙГЧИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА**

10. Угастай чихэвч, компьютерийн оролт порт, угастай чихэвч нь тохиргоо шаардахгүй, шууд залгаад ажилладаг, дууны чанар өндөр
11. Чанга яригч/өсгөгч
12. Хайгч тавагны оролт

Чухал тэмдэглэл: Компьютерын портыг төхөөрөмжний программ хангамжийг шинэчлэхэд ашиглана..

**АНХААР!** Холбогчийг ашиглаагүй үед тоосны хамгаалалтын тагийг үргэлж хаалттай байлгаарай!





## ДЭЛГЭЦИЙН ТОЙМ



1. Чийдэн & Блюютуз®
2. Дэлгэц шилжүүлэгч
3. Зайны цэнэгийн заалт
4. Арын гэрлийн түвшин

## ЭКСПЕРТ ТОХИРГООНЫ ЦЭС

MAGNETAR 9000 төхөөрөмжийн Мэргэжлийн цэс нь 3 салангид дэлгэц дамжсан нийт 12 өөр төрлийн тохируулга, үйлдийг агуулдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг 18–39 дүгээр хуудаснаас үзнэ үү..





## ХЯЛБАР ТОХИРГООНЫ ЦЭС

MAGNETAR 9000 төхөөрөмжийг анх асаахад Easy (Хялбар) болон Expert (Мэргэжлийн) гэсэн 2 өөр цэсний сонголтыг дэлгэц дээр харуулна.

Хялбар цэсээр хайлтаа үргэлжлүүлэхийн тулд баруун эсвэл зүүн шилжих товчлуурыг ашиглан Хялбар цэсийг сонгоно үү. 5 секундын дотор сонгох товчийг ашиглан сонголтоо баталгаажуулна. Төхөөрөмж бэлэн болтол хүлээнэ үү. Хэрэв та 5 секундын дотор сонголт хийхгүй бол төхөөрөмж хамгийн сүүлд сонгосон цэсээр үргэлжлүүлнэ.



АНХААР! Төхөөрөмж Хялбар цэс рүү ороход: Mode (Горим) нь Maximum дээр, ground (хөрс) нь Regular дээр, харин Ground Balance (Хөрсний тэнцвэржүүлэлт) нь auto (автомат) дээр тус тус шууд тохируулагна. Noise Cancel (Шуугиан дарагч) функцын хувьд зөвхөн автомат шуугиан дарагчийг ажиллуулах боломжтой. Автоматаар унтрах таймер /цаг хэмжигч/-ыг тохируулах боломжгүй (арын гэрэл үргэлж асаалттай хэвээр байна); гэсэн хэдий ч та гэрлийн түвшинг нэг түвшингээр нэмэх эсвэл бууруулах боломжтой.

АНХААР! Хялбар цэсэнд ажиллаж байх үед Bluetooth® тохиргооны спикер/өсгөгч идэвхгүй болдог. Спикерийг асаах эсвэл унтраахын тулд Мэргэжилтний цэс рүү нэвтрэх шаардлагатай..

Та мөн профайл товчийг ашиглан Эксперт /Мэргэжлийн/ цэснээс Хялбар /Easy/ цэс рүү хурдан шилжин орж болно.

Профайл товчлуурыг ашиглан Мэргэжлийн цэснээс Хялбар цэс рүү хэрхэн нэвтрэх вэ?

Профайл товчлуурыг дарахад гарч ирэх дэлгэц дээр Save сонголт руу шилжиж, профайл товчлуурыг дахин нэг удаа дарна үү.



Хялбар цэс рүү орохын тулд профайл товчийг дахин дар.



АНХААР! Хялбар цэснээс гарахын тулд профайл товчлуурыг дахин дарна үү.

## ЗАЙНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

MAGNETAR 9000-ын зай нь гадуур байрлалтай бөгөөд 6600mAh багтаамжтай Лити-ион зай юм.

Зайны ажиллах хугацаа нь 7-10 цагийн хооронд хэлбэлзэнэ. Хайгчийн тохиргоо, спикер, чихэвчний хэрэглээ, арын гэрэлтүүлэг, чийдэн болон бусад хүчин зүйлс нь батерейны ашиглалтын хугацаанд нөлөөлнө.

### Цэнэглэх

MAGNETAR 9000-ын зайг анх удаа ашиглахаас өмнө үргэлж бүрэн цэнэглэ.

Бүрэн суусан зайг цэнэглэх хугацаа ойролцоогоор 5 цаг байна.

Зайг цэнэглэхийн тулд төхөөрөмжтэй хамт дагалдаж ирсэн цэнэглэгч сууринд байрлуулна.



Цэнэглэгч кабелийн адаптерийг цахилгааны залгуурт, нөгөө үзүүрийг цэнэглэгч төхөөрөмжийн цэнэглэх оролтод холбоно.



АНХААР! Цэнэглэгч төхөөрөмжийн USB-C оролт нь 5В 0.67А чадлын гаралттай, энэхүү гаралтыг гар утас, повербанк г.м өөр төхөөрөмжийг цэнэглэхэд ашиглаж болно.



### Зайг цэнэглэх

MAGNETAR 9000-ын зайг цэнэглэх 3 өөр арга байдаг. Цэнэглэх үйл явцыг эхлүүлэхийн өмнө зайг хайгчаас салгаж, цэнэглэгч дээр байрлуулна; холбогч зүүнүүд бүрэн зэрэгцсэн эсэхийг шалгаарай.

Та цэнэглэгч төхөөрөмжийн ар талд байрлах залгуурт өөрийн хүссэн цэнэглэгч хэрэгслийг залгаснаар дараах аргуудын аль нэгийг ашиглаж болно:

1. Гэр/байшинд цэнэглэх - Wall Charger:  
Цэнэглэж эхлэхийн тулд цэнэглэгч адаптерийг стандарт ханын залгуурт залгана.
2. Автомашины цэнэглэгч - Car Charger:  
Машины цэнэглэгчээс зайг цэнэглэхийн тулд машины тамхины асаагуурын залгуурт кабелийг холбоно.
3. Машины зайнаас цэнэглэх - Car Battery Charging Cable:  
Чингэхийн тулд эхлээд хар сөрөг (-) хавчаарыг сөрөг шонтой холбож, дараа нь улаан эерэг (+) хавчаарыг эерэг буюу нэмэх шон /терминал/-той холбоно.

### Цэнэглэлтийн заагуур:

Зайг бүрэн цэнэглэх хүртэл нь үлдээгээрэй. Цэнэглэх явцад анивчих ногоон гэрэл батерейн цэнэг дүүрсэн үед тогтвортой ногоон гэрэл болж хувирна; энэ үйл явц дөрвөн цаг хүртэл үргэлжилж болно.

УСНЫ ХАМГААЛАЛТАЙ СОЛИГДДОГ НӨӨЦ ЗАЙ  
Зурагт үзүүлсэн шиг зайг хайгчийн хайрцгийн дээд  
хэсэгт байрлах үүрэнд хялбархан суулгана.




Та батерейг үүрнээс нь салгаж, дагалдах цэнэглэгчийг  
ашиглан амархан цэнэглэж болно.

**АНХААРУУЛГА!** Зайг үүрнээс нь салгасан үед төхөөрөмжийг  
бороонд эсвэл усан дотор үлдээж болохгүй!

Зайн цэнэг багасах түвшин

Төхөөрөмжийн дэлгэц дээрх зайний дүрс нь зайний  
цэнэгийн түвшинг харуулна. Зайний түвшин буурах тусам  
зайний дүрс доторх зураасны тоо буурдаг. Зай дууссан үед  
дэлгэц дээр батерей бага байгаа гэсэн дүрс гарч ирэх  
бөгөөд төхөөрөмж унтардаг.



**АНХААР!** Зай бага байгааг мэдэгдсний дараа буцах  
товчийг дарснаар төхөөрөмж автоматаар унтрах  
хүртэл удаан хугацаагаар ажиллах боломжтой.

### ЗАЙНЫ ТҮВШНИЙ АНХААРУУЛГА

Төхөөрөмжийг маш халуун эсвэл хүйтэн нөхцөлд  
(жишээлбэл, машин дотор эсвэл тээшинд) бүү орхи.

Зайг 35°C-аас дээш эсвэл 0°C-аас доош температурт  
цэнэглэж болохгүй.

## ЗАЙ ЦЭНЭГЛЭХ ЗААВАРЧИЛГАА

### Зай цэнэглэх техникийн үзүүлэлт

Төрөл: Цэнэглэдэг Лити-ион зай

Гаралтын хүчдэл: 7.2V DC

Багтаамж: 48Wh

Ажиллах хугацаа: 7–10 ца

Жин: 270 гр

**АНХААР!** Зайг цэнэглэхээр салгах болон буцааж  
суулгахдаа ус үл нэвтрэх битүүмжлэлийг хангахын  
түлд резин жийргэвч (gasket)-д маш сайн анхаарал  
хандуулж байгаарай.




Жийргэвчний гадаргуу дээрх шороо, элс, шавар  
зэрэг гадны биетийг төхөөрөмжид зайг буцааж  
оруулахаас өмнө сайтар цэвэрлэх шаардлагатай.  
Өөрөөр бол бол ус орж болзошгүй..

### Зайг цэнэглэх үеэд:

Цэнэглэгчийг адаптераар дамжуулан залгуурт  
холбоход Power LED нь ногоон өнгөөр гэрэлтэнэ. Зайг  
цэнэглэгч төхөөрөмжид суулгахад ногоон LED  
үзүүлэлт дараалан анивчих болно. Энэ дараалал нь  
батерей цэнэглэгдэж байгааг илтгэнэ.



Анхаар: Хэрэв зай цэнэглэгч төхөөрөмжид байх үед алдаа  
гарвал Алдааны LED тод улаан өнгөөр асна.



## ХАЙГЧИЙГ ЗӨВ ХЭРЭГЛЭХ НЬ

**Хайгчийн өндрийг буруу тохируулсан байна /зураг/**  
Хайгчийн уртыг өөрийн өндөрт тааруулахдаа биеэ цэх, гараа сул чөлөөтэй байлгаж, тавгийг газраас ойролцоогоор 5 см өндөрт байхаар тохируулна.

Хайлтын явцад таны биед эсвэл гуталд буй металл зүйлс нь төхөөрөмжид мэдрэгдэж, хуурамч дохио өгөх шалтгаан болдог.



**Төхөөрөмжийн өндрийг зөв тохируулсан байна /зураг/**  
Цэх зогсож, гараа сул тавин, таваг нь газраас ойролцоогоор 5 см орчим өндөрт байхаар хайгчийн өндрийг өөрийн биед тохируулаарай.

Металл хайгчийн өндрийг зөв тохируулснаар таны бие болон гуталд байгаа металл зүйлсээс шалтгаалах хуурамч дохионы эрсдэл мэдэгдэхүйц буурна.



## Зөв шүүрдэх арга техник

Хайлтын тавагны өнцөг буруу



Хайлтын тавагны өнцөг зөв



Шүүрдэх хөдөлгөөн буруу

Хайлтын ороомгийг газартай параллель барих нь үнэн зөв үр дүн гаргахад чухал ач холбогдолтой.



Шүүрдэх хөдөлгөөн зөв

Хайлтын тавгийг хайж буй хөрсний гадаргуутай үргэлж параллель (ижил түвшинд тэгш) байлгах ёстой.



## ХУРДАН ЭХЛЭХ - QUICK START

- 1) Төхөөрөмжийг 3-8 дугаар хуудас дахь угсралтын заавар хэсгээс харж угсарна уу.
- 2) Хайгчийг асаах/утраах товчийг 1 секунд дарж асаана. Nokta болон MAGNETAR 9000 гэсэн эхлэлийн дэлгэц гарсны дараа хялбар (Easy) болон Мэргэжлийн (Expert) цэсийг сонгох дэлгэц гарч ирнэ.



Баруун эсвэл зүүн навигацийн товчлуурыг дарж ашиглахыг хүссэн цэсээ сонго. Сонголтоо 5 секундийн дотор сонгох (Select) товчлуураар баталгаажуулна. Төхөөрөмжийг бэлэн болтол хүлээнэ.




АНХААР! Энэ хялбар (Easy) болон Мэргэжлийн (Expert) цэс нь хэрэглэгчийн эв дүйг сайжруулах, төхөөрөмжийн ажиллагааны уян хатан байдлыг хангах зорилготой. Анхлан суралцагч цаг алдалгүй өндөр гүйцэтгэл авахын тулд Хялбар цэсийг сонгох боломжтой. Харин мэргэжлийн хэрэглэгчид ахисан түвшний тохиргоог бүрэн ашиглахын тулд Эксперт цэсийг сонгоорой.

АНХААР! Хэрэв та сонголт хийхгүй бол MAGNETAR 9000 нь хамгийн сүүлд сонгосон тохиргоо, горимоор үргэлжлүүлэн ажиллах болно.

- 3) Хайгчийн Expert Menu дээр анх асаахад Mode (Горим) сонголт идэвхжсэн байна. Та хайлт хийх гэж буй газрынхаа хөрсний онцлогт тохируулан Дээш эсвэл Доош шилжих товчлуураар горимыг өөрчлөх боломжтой. Сонгосон горим нь дэлгэцийн баруун талд харагдана. Горимуудын тухай дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү гарын авлагын дараах хэсгүүдээс үзэж болно.



АНХААР! Дэлгэцийн баруун талын хэсэгт сонгосон үйлдлийн дэд сонголтууд харагдана. Таны хийсэн ямар ч тохиргооны өөрчлөлтийг баруун талаас хянах боломжтой.



### MAGNETAR 9000 газар тэнцвэржүүлэгчийн ач холбогдол

АНХААР! Хэрэв та хайгчийг газар тэнцвэржүүлэлт хийлгүй ашиглавал газраас хуурамч дохио хүлээн авч болзошгүй.

Хөрсний эрдэсжилт болон шуугианыг зохицуулах Дэлхийн хөрсний бүтэц зөвхөн элснээс бүрддэггүй, янз бүрийн химийн бодис, эрдэс баялаг, давс агуулдаг. Эдгээр нэмэлт бүрэлдэхүүн хэсгийг “Хөрсний эрдэсжилт” (Ground Mineralization) гэж нэрлэдэг.”

Хэрэв **Хөрсний тэнцвэржүүлэлт (Ground Balance)** хийхгүй бол энэхүү эрдэсжилт нь тогтворгүй дохио үүсгэж, улмаар хөрсний шуугиан (Ground Noise) буюу хөндлөнгийн саад бий болгоно. Улмаар газар дорх байны сул дохиог илрүүлэхэд хүндрэл учруулдаг.

**MAGNETAR 9000 ХАЙГЧИЙН ХӨРС ТЭНЦВЭРЖҮҮЛЭЛТ**  
**MAGNETAR 9000** Хайгчийн **Хөрсний тохиргоо**  
**(Ground Balance)** функц хөрсний эрдэсжилт (ground mineralization)- ийг нарийн хэмжиж, түүнд тохируулан өөрийгөө автоматаар зохицуулдаг. Энэхүү зохицуулах үйл явц нь хөрсний шуугианыг хамгийн бага түвшинд хүргэдэг.

Үүний үр дүнд, энэхүү оновчлол нь алт зэрэг үнэт металлын дохиог хөрснөөс үүдэлтэй хөндлөнгийн саадтай холилдохоос сэргийлж, тэдгээрийг маш тод ялган таних боломжийг олгодог.

4. Хэрэв та хүсвэл хоёр дахь дэлгэц дээрх **Sensitivity (Мэдрэгч чанар)** тохиргоог **Дээш** навигацийн товчлуураар ихэсгэж болно. Мэдрэгч чанарыг ихэсгэснээр илүү гүнээс хайх боломж олгоно. Гэвч хүрээлэн буй орчин эсвэл хөрснөөс шалтгаалан төхөөрөмж шуугиан хүлээн авч байвал **Доош** навигацийн товчлуурыг ашиглан Мэдрэгч чанарыг багасгах шаардлагатай. Мэдрэгч чанарыг тохируулсны дараа та хайлтаа эхлүүлж болно.



5) Та одоо хайж эхлэхэд бэлэн боллоо.

## ЭКСПЕРТ ЦЭС ТОХИРГООНЫ ЦЭС

Эдгээр тохиргоонд оруулсан өөрчлөлтүүд нь бүх **Горимд** (Modes) нэгэн адил үйлчилнэ. Сонгосон горимыг өөрчилсөн ч тохиргоонууд хэвээр үлдэнэ.

Энэхүү гарын авлагад **Мэргэжлийн цэс (Expert Menu)** болон тохиргооны цэсийг дараах байдлаар тэмдэглэв:

### Эксперт цэс Expert Menu



Горим



Хөрс



Шуугиан дарах



Газар тэнцвэржүүлэх



Мэдрэмж



Дууны түвшин



Суурь дуу



Суурь дууны үелзэл



Дууны шүүлтүүр



Тэнцвэржүүлэгч



Байны дуу





**Тохиргооны цэс**



Арын гэрэл



Блютүз®



Цэсний өнгө



Хэл



Товчны дуу



Товчны чичиргээ



Товчлуурын гэрэл



Чийдэн



Мэдээлэл




Үйлдвэрийн тохиргоо

## ГОРИМ

**MAGNETAR 9000** нь хөрсний өөр өөр нөхцөл болон байны төрлүүдэд тохируулсан 3 төрлийн **Горимтой** (Modes).

АНХААР! Үйлдвэрийн анхдагч тохиргоо нь Maximum /MAX/ Mode горим юм.



Горим Хооронд Шилжих:

Алт хайх, металл илрүүлэхэд тохирох горимыг сонгох нь таны хайлтын амжилтад шууд нөлөөлдөг. MAGNETAR 9000 нь янз бүрийн хэмжээ, гүнд тусгайлан тохируулсан 3 горимтой. Бүрүү горим сонгосноор байг алдахад хүргэж болзошгүй. Зөв тохиргоо сонгох нь илүү нарийвчлалтай үр дүнд хүрэхэд чухал алхам юм.

### ГОРИМЫГ ХЭРХЭН ӨӨРЧЛӨХ ВЭ?

Баруун эсвэл зүүн шилжих товчлуурыг ашиглан Мэргэжлийн цэсний Горим /mode/ сонголт руу очно уу. Дээш эсвэл доош навигацийн товчлууруудыг ашиглан ашиглахыг хүссэн Горимоо сонгоно. Сонгосон Горим дэлгэцийн баруун талд гарч ирнэ..





## Modes



### MAX

(Максимум горим): Жижиг цул алт болон гадаргууд ойрхон алтны үртэс хайхад зориулагдсан. Үндсэн Алтны горим юм.

Жижиг байнд өндөр мэдрэг чанартай байхаар бүтээгдсэн боловч дүнд хэмжээтэй болон дүнд зэргийн гүнд байрлах байнд маш мэдрэг. Энэ бол санал болгож буй Алт хайх орим юм..



### STANDARD

Стандарт горим: Ерөнхий зориулалтаар ашиглахад зориулагдсан. Бүхий л хэмжээний алтанд ижил мэдрэг чанартай. Маш жижиг болон/эсвэл гүний байг алгасаж магадгүй.



### DEEP

Гүний горим: Гүнд болон харьцангуй том хэмжээтэй байг хайхад зориулагдсан. Энэ горим нь жижиг алтны хэсгүүд болон/эсвэл гадаргууд ойрхон цэвэр алтыг илрүүлэхгүй эсвэл илрүүлэхэд бэрхшээлтэй байж болзошгүй

## ХЭРЭГЛЭГЧИЙН ТОХИРГОО

Профайл цэс нь хэрэглэгч төхөөрөмж дээр байнга ашигладаг хайлтын тохиргоог хадгалах, хадгалагдсан тохиргоонд хурдан хандах боломж олгоно. MAGNETAR 9000 нь хэрэглэгчийн тохиргоог шүүд хэрэгжүүлж, санах ойд хадгалдаг. Та төхөөрөмжийг унтрааж асаахад хамгийн сүүлд ашигласан тохиргоо нээгддэг. Өөрчлөлт хийх явцад байнга ашигладаг тохиргоонуудаа алдахаас сэргийлэхийн тулд та эдгээр тохиргоог профайл цэсээр дамжуулан төхөөрөмжийн санах ойд хадгалж болно. Ингэснээр та өөр өөр алт хайх орчинд дуртай тохиргоондоо хурдан эргэж орох боломжтой.

АНХААР! MAGNETAR 9000 нь таны тохиргоог хэрэглэгчийн ХУВИЙН САН /профайл/-д хадгалдаг.

АНХААР! Та зөвхөн Мэргэжлийн цэсэнд байх үедээ энэ профайл товчийг дарснаар л Профайл цэс рүү нэвтрэх боломжтой.


Хэрэглэгчийн профайлд хэрхэн хадгалах вэ?

Төхөөрөмж дээрх профайл товчийг дарж, баруун эсвэл зүүн навигацийн товчлуурыг ашиглан дэлгэцэн дээр гарч ирэх Хадгалах /save/ сонголт руу очно уу. Сонгох товчийг 3 секундын турш дарна.



Энэ нь төхөөрөмжийн яг тухайн үеийн тохиргоог хадгалах болно. Та төхөөрөмжийг асаах бүртээ эдгээр тохиргоог санах ойгоос ачаалж, энэхүү тохиргоог үргэлжлүүлэн ашиглаж болно.

АНХААР! Профайлыг хадгалах үйл явц дуусахад хадгалагдсан тохиргоог ачаалахын тулд Ачаалах /load/ сонголт идэвхждэг.



### Saveable Settings



Mode



Ground



Noise Cancel



Ground Balance



Sensitivity Volume



Threshold Volume



Threshold Frequency



Audio Filter Stabilizer



Target Volume

Хадгалсан тохиргоог хэрхэн устгах вэ?

Өмнө нь хадгалсан тохиргоогоо шинээр тохируулахын тулд төхөөрөмж дээрх профайл товчийг дарж, гарч ирэх дэлгэцэн дээрх баруун эсвэл зүүн навигацийн товчлуурыг ашиглан дахин тохируулах сонголт руу очно. Сонгох товчийг 3 секундын турш дарна.



Төхөөрөмж хадгалагдсан бүх тохиргоог устгаж, үйлдвэрийн анхдагч тохиргоо руу буцаана.

АНХААР! Өмнө дурдсанчлан, та профайл товчлуураар оруулсан профайл цэснээс Хялбар цэс рүү хурдан нэвтрэх боломжтой.

### ХАДГАЛСАН ТОХИРГОО SAVED SETTINGS

Хайгчийг ашиглаж байх үед хадгалсан тохиргоонд өөрчлөлт оруулсан тохиолдолд өмнө нь хадгалсан тохиргоо руугаа буцах боломжийг олгоно.

Хадгалсан тохиргоог хэрхэн гаргаж ирэх вэ?

Төхөөрөмж дээрх профайл товчийг дарж, баруун эсвэл зүүн навигацийн товчлууруудыг ашиглан дэлгэцэн дээр гарч ирэх Ачаалах /load/ сонголт руу очно. Сонгох товчийг 3 секундын турш дарна.



Хялбар цэсэнд байхдаа та профайл товчийг дарж Мэргэжлийн цэс рүү хурдан шилжиж болно.



## ШУУГИАНДАРАХ NOISE CANCEL

Гадаад орчноос (ойролцоо ажиллаж байгаа бусад мэдрэгч, өндөр хүчдэлийн цахилгааны шугам, гар утасны цамхаг, радио г.м бусад цахилгаан соронзон төхөөрөмж) цахилгаан соронзоны хөндлөнгийн нөлөө хайгчийн мэдрэг чанарыг бууруулдаг хүчин зүйл юм. Шуугианыг зогсоох тохиргоог хөндлөнгийн ийм нөлөөнөөс холдож, илүү тайван, илүү мэдрэмтгий хайлт хийхэд ашигладаг. MAGNETAR 9000 нь 255 давтамжийн суваг санал болгодог бөгөөд хамгийн хүчтэй дуу чимээтэй орчинд ч ажиллах боломжийг бүрдүүлдэг юм.

АНХААР! Үйлдвэрийн анхдагч тохиргоо нь 128.

MAGNETAR 9000-г ашиглахаас өмнө хийх ёстой хамгийн эхний үйлдэл бол дуу чимээг намсгах явдал юм.



Хайлтын тавгийг агаарт барьж байхад төхөөрөмж хэт их чимээ шуугиан мэдрэвэл шалтгаан нь хүрээлэн буй орчноос ирж буй цахилгаан соронзон дохио юм. Энэ тохиолдолд Дуу чимээг цуцлах тохиргоог ашиглахыг зөвлөж байна. Хамгийн их гүнд хүрэхийн тулд эхлээд хүрээлэн буй орчноос ирж ийм дуу чимээг Шуугиан дарах /noise cancel/ үйлдлийг ашиглан засах хэрэгтэй. Мөн төхөөрөмжийг асаах бүрт Дуу чимээг цуцлах энэ үйлдлийг гүйцэтгэж байгаарай.

АНХААР! MAGNETAR 9000 дээрх дуу чимээг дарах ажиллагааг 2 аргаар гүйцэтгэдэг: гар болон автомат.

Гараар тохируулахдаа дууны суваг бүрийг сонсож хамгийн сул шуугиантайг нь сонгоно.

Автоматаар тохируулахдаа төхөөрөмжийн бүх сүвгийг сканнердаж, хамгийн бага чимээтэйг нь сонгоно. Энэ үйлдэл буюу функцийг Дуу чимээг цуцлах /Noise Cancel/ тохиргоо гэж нэрлэдэг.

Гар аргаар шуугиан дарах тохиргоог хэрхэн хийх вэ? Зүүн эсвэл баруун талын шилжих товчлууруудыг ашиглан Мэргэжлийн цэсний Дуу чимээг цуцлах сонголт руу оч. Дээш эсвэл доош навигацийн товчлуурыг ашиглан хайгчийн аудио хариу үйлдлийг анхааралтай сонсож, боломжтой сүвгүүдээр ээлжлэн солино уу. Хамгийн бага хөндлөнгийн шуугиантай сүвгийг сонгоно. Сонгосон сүвгийн утга дэлгэцийн баруун талд харагдана.



Автомат аргаар шуугиан дарах тохиргоог хэрхэн хийх вэ?


1. Баруун, зүүн сумаар Мэргэжлийн цэсний Шуугиан дарах **Noise Cancel** цэс рүү очоод сонгох товчийг дарна



2. Сонгох **select button** товчийг дарахад дэлгэц дээр автоматаар сканнердах үйл явц эхэлнэ.




3. Зурагт үзүүлсэн шиг хайгчийг агаарт өргөж, сканнер дуустал (ойролцоогоор 50 секунд) тогтвортой барь. Ойролцоо том металл эд зүйл байгаа эсэхийг шалгаарай.



Таны төхөөрөмж эхнийхээс нь эхлэн бүх сувгийг сканнердана. Процесс дууссаны дараа дэлгэц дээр баталгаажуулах тэмдэг гарч ирэх бөгөөд сканнер дууссаныг илтгэх баталгаажуулах дуу сонсогдоно..



Автоматаар тодорхойлсон сувгийн утга дэлгэцийн баруун талд гарч ирнэ.



АНХААР! Шуугиан дарах үйл явц нь орчны дуу чимээ зэрэг саад тоггорын дохиог багасгаж, таны төхөөрөмж илүү цэвэр дохио хүлээн авах боломжийг олгодог.

## ГАЗАР ТЭНЦВЭРЖҮҮЛЭХ



Газрын тэнцвэр нь хайгчийн хувьд хөрсний эрдэст дасан зохицох чухал үйл явц юм.

Хөрсөнд агуулагдах төмрийн исэл, давсны эрдэс бодис, бусад дамжуулагч элемент нь хайгчийг хуурамч дохио гаргахад хүргэдэг. Газрын тэнцвэржүүлэгчгүй төхөөрөмж нь металл бус эрдэс бодисыг металл гэж үзэж болно. Хуурамч дохио нь шаардлагагүй ухалт, цаг хугацаа алдахад хүргэнэ. Газрын тэнцвэржүүлэгчийн гохыг ашиглах нь энэ хайгчийн хамгийн чухал онцлогуудын нэг юм. Феррит цагирагтай гохыг ашиглан Газрын тэнцвэржүүлэлтийг хийх нь нарийвчлалтай тохируулгын хувьд маш чухал үйлдэл юм.

Газрын зөв тэнцвэр нь гүний жижиг алтыг ч илрүүлэх чадварыг сайжруулна. Ялангуяа хүнд эсвэл эрдэсжсэн газарт байг алдахаас сэргийлж, илүү тогтвортой хайлтыг бий болгодог. Газрын дуу чимээг бууруулснаар жинхэнэ бай дээр анхаарлаа төвлөрүүлэх боломжийг олгодог. Алтны эрэл хайгуулыг үр дүнтэй явуулахын тулд газрын зөв тэнцвэр нь нэн чухал юм.

АНХААР! Зөв хийсэн Газар тэнцвэржүүлэх тохиргоо нь илүү гүнзгий, илүү нарийвчлалтай, илүү тогтвортой хайлтыг хангаж, таныг хуурамч дохионоос аварна.

MAGNETAR 9000 нь янз бүрийн газрын нөхцөлд сайн ажилахын тулд 3 өөр газрын тэнцвэрийн тохиргоог санал болгодог. Тохиргоо бүрийг газрын төрөл болон хэрэглээний хэрэгцээнд тохируулан өөрчилнэ.

АНХААР! Үйлдвэрийн анхдагч Газар Тэнцвэржүүлэх тохиргоо нь автомат байна.

ГАЗАР ТЭНЦВЭРЖҮҮЛЭГЧИЙГ ХЭРХЭН ХИЙХ ВЭ?

Баруун, зүүн сум товчлуураар Мэргэжлийн цэсний Газар сонголт руу оч. Дээш, доош шилжих товчлуурыг ашиглан ашиглахыг хүссэн Газар Тэнцвэржүүлэх сонголтыг сонгоод сонгох товчийг дарж сонголтоо баталгаажуулна. Сонгосон Газрын Тэнцвэрийн тохиргоо дэлгэцийн баруун талд гарч ирнэ.



АНХААР! Сонголтоо идэвхжүүлэхийн тулд : selection товчийг дарж шинэ горимыг баталгаажуулна.

АНХААР! Газрын Тэнцвэрийн горимыг өөрчилж, өөр горимыг баталгаажуулахад дэлгэцэн дээр гарч буй хөдөлгөөнт дүрс нь феррит цагираг ашиглан Газрын Тэнцвэрийг дахин хийх шаардлагатайг зааж буй хэрэг юм. Үгүй бол та хөндлөнгийн дохио хүлээн авсаар байх болно.



## Газар тэнцвэржүүлэх сонголтууд

АНХААР! Механик эсвэл хагас автомат горимыг сонгосон үед хайлтаа эхлүүлэхийн өмнө феррит цагирагтай хогыг ашиглан Газрын тэнцвэрийг заавал хийхийг зөвлөмж болгож байна!



### АВТОМАТ

"Auto" (автомат) тохиргоон дээр таны төхөөрөмж хөрсний цахилгаан дамжуулах болон соронзон нөхцөлийн өөрчлөлтийг хянаж, хөрснөөс үүсэх хуурмаг дохиог багасгана. Энэ нь соронзон агууламж өндөртэй хөрсөнд "semi auto" (хагас автомат) горимтой харьцуулахад илүү тогтвортой хайлт хийх боломжийг олгоно.



### ХАГАС АВТОМАТ SEMI AUTO

Хагас автомат тохиргоон дээр, Таны хайгч хөрсний цахилгаан дамжуулах чанарын өөрчлөлтийг хянаж, хөрснөөс үүсэх хуурмаг дохиог багасгана. Хэрэв Та хайгчийг өөр өөр төрлийн хөрсөнд ашиглаж буй бол хагас автомат тохиргоо нь илүү тохиромжтой.



### ГАР АЖИЛЛАГАА MANUAL

ГАР тохиргоон дээр хөрсний хяналт (ground tracking) идэвхгүй болох ба MAGNETAR 9000-ийн хөрсний загварт хөрсний нөхцөл байдлын өөрчлөлт шинэчлэгдэхгүй. Минералын бүтэц нь тогтвортой, өөрчлөгддөггүй бүс нутагт анхны хөрсний тохируулга (Ground Balance)-ыг хийсний дараа энэ тохиргоог ашиглаж болно.

Автомат Газар Тэнцвэржүүлэлт Auto Ground Balance Алт илрүүлэх хайлтыг эхлүүлэхийн өмнө зөв газрын тэнцвэрийг хийх нь хуурамч дохио болон газартай холбоотой нөлөөллөөс урьдчилан сэргийлэх чухал алхам юм. Зөв гүйцэтгэсэн газрын тэнцвэр нь таны төхөөрөмжийн мэдрэг чанарыг нэмэгдүүлж, илүү найдвартай үр дүнг өгнө.

Газрын Тэнцвэрийг Хэрхэн Хийх вэ? Ground Balance Хуурамч дохионоос сэргийлэхийн тулд металаас ангид, цэвэр хөрсний гадаргууг сонгоно уу. **MAGNETAR 9000** төхөөрөмжийн шар өнгийн феррит цагиргийг газарт тавина. Триггер (гогцоо)-ийг татаж, дэлгэц дээрх зааврыг дагаарай. Хайгч тавгийг (Search Coil) газраас ойролцоогоор 4-5 см өндөрт барьж, хажуу тийш нь савлуулна. Хөдөлгөөний түршид газраас ижил өндөрт барьж, феррит цагираг дээгүүр мөн давуулж савлуулна. Феррит цагираг болон хөрсний алиных нь ч дуут дохио сонсогдохгүй болох хүртэл үргэлжлүүлэн савлуулна уу.

Хажуу тийш савлуулах нь **Ground Balance** (Хөрсний тэнцвэрт байдал тохируулах)-ийн үндсэн арга бөгөөд дээш доош (шахах) хөдөлгөөн хийхийг зөвлөдөггүй. Шахах хөдөлгөөнийг **Ground Balance** дууссаны дараа хөрсний үлдэгдэл нөлөөг шалгах зорилгоор ашиглаж болно. **Ground Balance**-ийг зөвхөн төхөөрөмжийг асаах үед ч биш, харин алт хайх явцад хуурамч дохио өгч эхэлбэл (ялангуяа механик болон хагас автомат горимд) триггерийг ашиглан хэзээ ч дахин хийх боломжтой.



**Феррит цагираг ашиглан Газар тэнцвэржүүлэлт хийх**

Тогтвортой соронзон нэвтрүүлэх чанар бүхий феррит цагираг нь турших байны үүрэг гүйцэтгэнэ. Хайгчийг тохируулгыг шалгахдаа таваг болон феррит цагиргийг хамтад нь ашиглаж хийнэ. Феррит цагираг нь хөрсөнд түгээмэл байдаг соронзон шинж чанарыг төвлөрүүлэн харуулдаг лавлагаа болдог. Соронзон шинж чанар султай бүс нутагт феррит цагиргийг ашиглан шалгах тохируулга хийх нь **Ground Balance**-ийг нарийн тохируулахад чухал юм. Феррит цагираг нь тогтмол соронзон нэвтрүүлэх чанартай тул тодорхой хариу урвал үзүүлнэ. Энэ нь түүнийг Ground Balance-ийг тохируулах лавлагаа загвар болгодог.

Феррит цагираггүйгээр тохируулга хийвэл юу болох вэ? Феррит цагираггүйгээр Ground Balance хийх нь шалгалт тохируулгын ерөнхий чанарыг бууруулж, дараах асуудлуудыг үүсгэж болзошгүй:

1. Төхөөрөмж хуурамч дохио авч, жижиг металлыг илрүүлэх мэдрэмж буурч болно.
2. Төхөөрөмжийн металл илрүүлэх гүн багасч болно. Ерөнхий ажиллагаа, нарийвчлалд сөрөг нөлөө үзүүлж болно. Иймд Ground Balance-ийг феррит цагирагтай хийх нь хайгчийг маш өндөр бүтээмжтэй ажиллуулж, металлыг үнэн зөв илрүүлэх амин чухал алхам юм.

**МЭДРЭМЖ SENSITIVITY**

Энэ нь төхөөрөмжийн гүнийг тохируулах тохиргоо юм. Мөн орчны цахилгаан соронзон үүсгүүрүүд, хөрснөөс ирж буй шуугиантай дохиог удирдахад ашиглагдана.

Мэдрэмжийн түвшинг нэмснээр **MAGNETAR 9000** нь илүү жижиг, гүнд буй байг илрүүлэх боломжтой болно. Гэвч мэдрэмжийг хэт өндөр тохируулах нь орчны цахилгаан соронзон дохио (цах. сугам, радио, үүрэн холбооны цамхаг г.м) болон хөрсний шуугиант дохионоос (эрдэс бодис, давс, төмрийн оксид) үүдэлтэй хуурамч дохио гарахад хүргэж болзошгүй.

Иймд мэдрэмжийн хамгийн тохиромжтой түвшинг хайгч хамгийн их гүнд тогтвортой ажиллах, шуугиан ба хуурамч дохио хамгийн бага байх цэгт тохируулах шаардлагатай.

Хайх явцад фон шуугиан бага зэрэг сонсогдох нь хэвийн үзэгдэл бөгөөд энэ нь гүнд байгаа байг алдалгүй илрүүлэхэд тустай. Орчин хэт чимээгүй байх нь мэдрэмжийг хэт буруулснаас үүдэн гүнд байгаа байг илрүүлэхгүй байж болохыг илтгэнэ.

**АНХААР!** Мэдрэмж нь 20 алхамтай бөгөөд анхдагч тохиргоо нь 15 байна.

Мэдрэмжийн түвшин нь хэрэглэгчийн хувийн сонголт юм. Гэсэн хэдий ч жижиг болон гүнд байгаа байг алдаж өнгөрөөхөөс сэргийлэхийн тулд чанга шуугианы тэсрэлт сонсогдохгүй, харин бага зэргийн фон шуугиантай байх хамгийн дээд утга дээр мэдрэмжийг тохируулах нь чухал.

Дээрх зарчмын дагуу, жишээ нь: мэдрэмжийн 15 болон 20 гэсэн түвшнүүд дэх шуугианы хэмжээ хоорондоо ойролцоо бөгөөд хайгуул хийхэд тохиромжтой байвал 20 гэсэн түвшинг сонгох хэрэгтэй.

Мэдрэмжийн тохиргоо нь бүх горимд ижил үйлчлэх тул аль нэг тохиргоог өөрчлөхөд бүх горимд шууд нөлөөлнө.

**Мэдрэмжийг Хэрхэн Тохируулах вэ? Sensitivity**

**Эксперт цэс (Expert Menu)** рүү орж, баруун эсвэл зүүн навигацйон товчлуурыг ашиглан **Sensitivity** (Мэдрэмж) сонголт руу шилжинэ. Дээш эсвэл доош шилжих товчлуурыг ашиглан мэдрэмжийн утгыг нэг нэг алхмаар нэмэгдүүлж, эсвэл бууруулна. Сонгосон мэдрэмжийн утга дэлгэцийн баруун талд гарч ирнэ.



Та төхөөрөмжийг асаахад хамгийн сүүлд тохируулсан мэдрэмжийн түвшингээс хайлт чинь эхэлнэ.

**АНХААР!** Мэдрэмжийг хэт их бууруулахын оронд, хамгийн их гүнд хүрэхийн тулд, хүрээлэн буй орчноос цахилгаан соронзон дохионоос үүдэлтэй чимээг арилгахын тулд эхлээд Шуугиан дарах тохиргоог зөв хийхийг зөвлөж байна..



## ДУУНЫ ТОХИРГОО VOLUME



Дууны түвшний тохиргоо нь танд орчны нөхцөл байдал эсвэл хувийн сонголтынхоо дагуу илрүүлэгчийн нийт дууны түвшинг хянах боломжийг олгодог.

АНХААР! Дууны чанга сул нь 20 шатлалтай бөгөөд анхны үндсэн тохиргоо нь 15 байна.



Дууны 1-р түвшинд сул дохионууд намуухан, дунд зэргийн дохио хэвийн хэмжээнд, харин хүчтэй дохионууд чанга сонсогдоно. Энэ тохиргоон дээр дохионы хүч хоорондын дууны чанга сулын ялгаа хамгийн тод мэдэгддэг. Гэсэн хэдий ч сул дохиог сонсоход илүү хүндрэлтэй байж болно..



Дууны 20-р түвшинд бүх дохио өндөр чангалалтай тод сонсогдоно. Энэ тохиргоон дээр дунд болон хүчтэй дохионы чанга сулын ялгаа багасах боловч сул дохионуудыг сонсоход илүү хялбар болдог. Хайгчийг үр дүнтэй ажиллуулахын тулд энэхүү тохиргоог хайгуул хийж буй орчин болон байны гүнээс хамааруулан тохируулах боломжтой.

АНХААР! Анир чимээгүй орчинд дууны сул түвшнийг сонгох нь тохиромжтой байдаг бол сул дохионуудыг алдахгүй байх нь чухал үед дууны түвшнийг илүү өндөр дээр тохируулахыг зөвлөдөг.

## Дууг Хэрхэн Тохируулах вэ How to Adjust Volume?

Баруун, зүүн шилжих товчоор Мэргэжлийн цэсний Дууны түвшин сонголт руу очно. Дээш эсвэл доош навигацийн сумыг ашиглан дууны түвшинг нэг шатаар нэмэгдүүлж эсвэл бууруулна. Сонгосон дууны түвшин дэлгэцийн баруун талд гарч ирнэ.



## СУУРЬ ДУУ THRESHOLD VOLUME



MAGNETAR 9000-ийн өөрийнх нь тасралтгүй "хунгинэх" дууг босго буюу суурь гэж нэрлэдэг. Хайгчийн суурь дуу хайгчийн мэдрэмжийг нэмэгдүүлэх, сул дохиог сонсоход илүү хялбар болгох зорилготой. Энэ нь маш жижиг эсвэл гүний алтан байг илрүүлэхэд чухал үүрэгтэй.

Энэхүү суурь дуу бага зэрэг өөрчлөгдөх нь бай байгааг илтгэнэ. **Threshold**-ийн дууны чангыг тохиромжтой хэмжээнд байлгах нь фон шуугианаас үндсэн дохиог ялгахад хялбар болгоно.

**Threshold**-ийг маш бага, дөнгөж сонсогдох төдий түвшинд тохируулах нь хамгийн сайн үр дүнг авчирна. Ингэснээр байны дохио цаад шуугианаас маш тод ялгарч сонсогдох болно.

Энэхүү тохиргоог хэт өндөр хийвэл чанга шуугианы улмаас маш сул дохиог сонсоход хэцүү болно. Түүнчлэн тасралтгүй чанга шуугиан сонсох нь чихэнд чийртэй, хуурамч дохиог ялгахад төвөгтэй болгодог.

АНХААРГ! **Threshold**-ийн дууны чангыг өөрт чинь тодорхой сонсогдохоор, гэхдээ чихэнд чирэгдэлгүй, түхтэй байх түвшинд тохируулна уу. Сул дохионууд энэхүү цаад шуугианаас тод ялгарч, хялбархан анзаарагдахаар байх ёстой..

АНХААР! **Threshold Volume** нь 20 шатлалтай (түвшинтэй) бөгөөд анхны (үндсэн) тохиргоо нь 25 дээр байдаг.

Суурь дууг Хэрхэн Тохируулах вэ? **Threshold**

**Эксперт цэс (Expert Menu)** рүү орж, баруун эсвэл зүүн шилжих товчлуурыг ашиглан **Threshold Volume** сонголт руу шилжинэ. Дээш эсвэл доош навигацийн товчлуурыг ашиглан дууны утгыг нэг нэг шатлалаар нэмэгдүүлж, эсвэл бууруулна. Сонгосон утга дэлгэцийн баруун талд харагдах болно.



## СУУРЬ ДУУНЫ ҮЕЛЗЭЛ



Хайгчийн суурь дууны үелзэл/давтамжийг (өнгийг) тохируулахад ашиглана.

**Threshold** буюу хайгчийн өөрөөс нь гарах дууны давтамж нь хайгчийн энэхүү суурь шуугиан ямар өнгөөр - өндөр (нарийн) эсвэл сул (нам/бүдүүн) сонсогдох байдлыг тодорхойлно.

АНХААР! Хүн бүрийн сонсголын мэдрэмж өөр өөр байх тул суурь дууны үелзлийг өөрийн чихэнд хамгийн тухтай, тааламжтай түвшинд тохируулах нь байны дохиог илүү хялбар ялгаж сонсоход тусална.

АНХААР! Босго дууны давтамж нь 100 шатлалтай бөгөөд анхдагч тохиргоо нь 53 байна.

### Суурь Дууны Давтамжийг хэрхэн тохируулах вэ?

Баруун эсвэл зүүн шилжих товчийг дарж Мэргэжлийн цэсний Суурь Дууны Давтамж /Threshold Frequency/-ийн сонголт руу очно. Дээш эсвэл доош заасан сүм товчлуурүүдийг ашиглан суурь давтамжийн утгыг нэг шатлалаар нэмж эсвэл бууруулна. Сонгосон босго давтамжийн утга дэлгэцийн баруун талд гарч ирнэ.



## ДУУНЫ ШҮҮЛТҮҮР AUDIO FILTER



MAGNETAR 9000-г ажиллуулж байх үед заримдаа газрын дохионы хэлбэлзэл нь хайлтын үйл явцыг хүндрүүлдэг.

Байнга өөрчлөгдөж буй суурь дууны шуугиан дунд металл байг илрүүлэх явц хүндрэлтэй болж болно. Аудио шүүлтүүрийг **Унтраалттайгаас Өндөр /from Off to High/** болгож нэмэх тусам суурь дуу илүү жигд, нам гүм болдог.

Дууны шүүлтүүр нь газрын хэлбэлзлийг бууруулж, илүү тогтвортой дуу /аудио/ гаралтыг бий болгодог. Энэ нь хэрэглэгч зөвхөн металл илэрсэн үед л тодорхой өөрчлөлтийг сонсох боломж олгоно, ингэснээр хайлтын илүү тав тухтай байдлыг бий болгодог.

АНХААР! MAGNETAR 9000 Хайгчийн Audio Filter (Дууны шүүлтүүр) нь үйлдвэрийн тохиргоондоо унтраалтай байдаг.

MAGNETAR 9000 нь бүх төрлийн хөрсөнд дээд зэргийн мэдрэмжтэй ажиллахаар зохион бүтээгдсэн. Гэсэн хэдий ч зарим тохиолдолд хөрсний нөлөөллийг саармагжуулахын тулд Audio Filter (Аудио шүүлтүүр) үйлдлийг ашиглаж болно.

### Аудио шүүлтүүрийг хэзээ ашиглах вэ?

1. Хөрснөөс үүдэлтэй дохионоос болж дууны хэлбэлзэл хэт ихсэх үед,
2. Мэдрэмжийн түвшнийг (**Sensitivity**) бууруулах эсвэл суурь дууны түвшнийг (**Threshold volume**) тохируулах нь эдгээр нөлөөллийг хангалттай арилгахгүй байх үед,
3. Хайлтын үеийн дууг илүү тогтвортой байлгахыг хүссэн үедээ аудио шүүлтүүрийг ашиглаж болно.

АНХААР! Аудио шүүлтүүрийг идэвхжүүлсэн үед жижиг металл бай дээр мэдрэх чанар нь буурч магадгүй.

**Дууны шүүлтүүрийг хэрхэн тохируулах вэ? Audio Filter**  
Баруун, зүүн шилжих сүм товчоор Мэргэжлийн цэсний Аудио шүүлтүүрийн сонголт руу очно. Дээш, доош шилжих сумаар хүссэн дууны шүүлтүүрийн сонголтгоо сонгоно уу. Сонгосон аудио шүүлтүүрийн тохиргоо дэлгэцийн баруун талд гарч ирнэ.



Дууны шүүлтүүр нь хэрэглэгчийн хэрэгцээнд үндэслэн 3 өөр түвшний сонголтыг санал болгодог:



### 1. Унтраалттай Off

Аудио шүүлтүүр идэвхгүй байна. Бүх газрын дохио /signal/-г боловсруулж, хамгийн их мэдрэмж чанарыг өгнө.



### 2. Бара Low

Ялимгүй хэлбэлзлийг шүүнэ. Дунд зэргийн хүндрэлтэй хөрсний нөлөөллийг багасгаж, хайлтын тэнцвэртэй байдлыг хангана.



### 3. Өндөр High

Илүү хүчтэй шүүлтүүр хэрэглэнэ. Хөрсний нөлөөллийг хамгийн бага хэмжээнд хүргэж, зөвхөн тод илрэх металл байднд анхаарна.

## ТОГТВОРЖУУЛАГЧ STABILIZER



Тогтворжуулагч нь хайгчийг далайн эрэг г.м давстай газар дээр илүү тогтвортой болгож, илүү найдвартай хайлтын орчин бий болгоно..

АНХААР! MAGNETAR 9000 үйлдвэрийн тохиргоонд тогтворжуулагч нь унтраалттай байна.

Давсархаг хөрсөнд металл хайгч нь яг металл байгаа мэт үргэлжилсэн урт дохиог байнга өгдөг. Энэ нь бодит металл байг эдгээр дохион дунд төөрөгдүүлж, хэрэглэгчид жинхэнэ металлыг ялгаж танихад хүндрэл учруулдаг. Тогтворжуулагч (Stabilizer) нь ийм төрлийн дохиог зохицуулж, илүү тодорхой, ялгагдахуйц хайлтын үр дүнд хүрэхэд тань тусална.

ЧУХАЛ! Тогтворжуулагч хайгуулын гүнийг багасгаж болзошгүй. Тиймээс зөвхөн давстай хөрсөнд (хужирхаг газар) ашиглах нь илүү зохимжтой.

### Тогтворжуулагчийг (Stabilizer) хэзээ хэрэглэх вэ?

Хайгч тань давстай хөрсөнд (далайн дагуух эрэг, эрдэсжилт өндөртэй хөрс гэх мэт) тогтворгүй, замбараагүй дохио өгөх, яг металл байгаа мэт үргэлжилсэн урт дохио үүсгэх, мөн эдгээр дохион дунд бодит металлыг илрүүлэхэд хүндрэлтэй болох үед та Тогтворжуулагчийг хэрэглэх шаардлагатай.

### Тогтворжуулагчийг хэрхэн тохируулах вэ? Stabilizer

Баруун, зүүн сум товчийг ашиглан Мэргэжилтний цэс (Expert Menu) доторх Тогтворжуулагч сонголт руу шилжинэ. Дээш, доош товчлуураар ашиглахыг хүссэн Тогтворжуулагчийн тохиргоог сонгоно. Сонгосон тохиргоо нь дэлгэцийн баруун талд харагдана.



Тогтворжуулагч нь хэрэглэгчийн хэрэгцээнд үндэслэн 3 өөр түвшний сонголтыг санал болгодог:



### 1. Унтраалттай Off

Хэрэв хайгч тань хэвийн ажиллаж байгаа эсвэл хужиртай хөрсний нөлөө мэдрэгдээгүй бол тогтворжуулагчийг унтраасан байх ёстой. Энэ нь байг хамгийн гүнд мэдрэх боломж олгоно.



### 2. Бара Low

Хэрэв хайгч бага зэрэг давслаг эсвэл эрдэсжсэн хөрсөн дээр тогтворгүй дохио гаргаж буй бол бага түвшинг сонго. Энэ нь тогтвортой байдлыг хангана. Гүний алдагдал маш бага байдаг. Энэ тохиргоо нь танд илүү том талбайг богино хугацаанд хамрах боломж олгоно.



### 3. Дунд Medium

Хэрэв хайгч маш хужирлаг, хэт эрдэсжсэн хөрсөн дээр маш их гажсан дохио гаргаж буй бол дунд түвшинг ашиглах хэрэгтэй. Энэ тохиргоонд төхөөрөмжийн зорилтот хариу үйлдлийн хурд нэмэгдэж, суурь дуу чимээ илүү идэвхтэй болно. Гэвч бусад түвшинтэй харьцуулахад гүний алдагдал илүү их байж болно.

## БАЙНЫ ДУУ TARGET VOLUME



**Байны дууны хэмжээ** нь байны дохионы дээд дууны түвшнийг тохируулна. Энэ нь ялангуяа гүехэн газарт байгаа том биет (бай) илрэх үед гэнэтийн чанга дуу чимээ гарч, таны сонсголыг гэмтээхээс сэргийлнэ.

**Дууны дээд хязгаар өндөр үед (High Volume Limit):** Том болон жижиг бай хоорондох дууны хэмжээний ялгааг илүү тод болгоно. Гүн болон сүл дохиог сонсоход илүү хялбар болох бөгөөд байны хэмжээ, гүнийг хайгчаар баримжаалахад тусална. Гэсэн хэдий ч гадаргуутай ойрхон том биет илрэх үед гэнэт чанга дуу гарч, чихэнд чийртэй байж болзошгүй.

**Дууны дээд хязгаар бага үед (Low Volume Limit):** Том болон жижиг бай хоорондох дууны хэмжээний ялгааг багасгана. Гэнэтийн чанга дуу гарахаас сэргийлэх тул хайгчийг удаан ашиглахад илүү таатай байна. Чихэвч ашиглаж байх үед сонсголыг тань хамгаална. Гэвч дууны түвшний ялгаа багасах тул дууны хэмжээгээр нь том, жижиг байг ялгахад хэцүү байж болно.

АНХААР! Хэрэв та чихэвч ашиглаж байгаа бол бага-дунд түвшинд тохируулна уу.

ЧУХАЛ! Сүл байг хайх үед дууны хэмжээг хязгаарлах нь илүү сайн үр дүнг өгдөг.

Шуугиантай орчинд дунд тохиргоо нь **сонсголын хамгийн тэнцвэртэй мэдрэмжийг** олгоно. Харин удаан хугацаагаар хайгуул хийх үед чих чилэхээс сэргийлж бага түвшинг сонгоорой.

АНХААР! Байны дууны тохиргоо нь 20 түвшинтэй бөгөөд анхдагч тохиргоо нь 15 байна.



**Байны дууны түвшинг хэрхэн тохируулах вэ?**

Баруун, зүүн сумаар Мэргэжлийн цэсний Байны дууны түвшин сонголт руу очно. Дээш, доош сум товчоор Байны дууны түвшинг нэг шатаар нэмж эсвэл бууруулна. Сонгосон байны дууны түвшин дэлгэцийн баруун талд гарч ирнэ.

## ТОХИРГООНЫ ЦЭС SETTINGS



MAGNETAR 9000 тохиргооны цэс нь 3 тусдаа дэлгэцээс бүрдэнэ. Дэлгэцийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг дорх хуудаснаас үзнэ үү.



Тохиргооны цэс нь MAGNETAR 9000 хайгчийн **ашиглах аргыг** өөртөө тохируулах болон хамгийн сайн түвшинд тохиргоог уялдуулах боломж олгоно. Дор дурдсан хэсгээс цэсэнд байгаа бүх сонголт болон тэдгээрийн үүргийг харах боломжтой:



### 1. Арын гэрэл Backlight

Дэлгэцийн гэрэлтүүлгийн тод сулыг тохируулах замаар зайны хэрэглээг хэмнэх боломжтой.



### 2. Бluetooth Bluetooth®

Та Bluetooth® холболтыг асаах, унтраах, мөн хайгчтай холбох (хослуулах) үйлдэл хийх боломжтой.



### 3. Цэсийн өнгө Menu Colors

Дэлгэцийн өнгийг өөрчилнө.



### 4. Хэл Language

Хайгчаа ямар хэлээр ажиллуулахаа сонгоно.



### 5. Товчлуурын дуу Key Sounds

Товчлуудын дууг асаах эсвэл унтраана.



### 6. Товчлуурын чичиргээ Key Vibration

Товчлуурыг асаах эсвэл унтраах үед чичиргээний хариу үйлдлийг асааж болно.



### 7. Товчлуурын гэрэл Key Backlight

Харанхуй орчинд ашиглахын тулд товчлуурын арын гэрлийг асаах эсвэл унтраана.



### 8. Чийдэн Flashlight

Гар чийдэнг асаах эсвэл унтраах боломжтой.



### 9. Хайгчийн мэдээлэл Device Info

Хайгчийн программ хангамж /hardWare, softWare/-ийг үзэж болно.



### 10. Үйлдвэрийн тохиргоо Factory Reset

Та бүх тохиргоог дахин эхлүүлэхээр шинэчлэн (ресет хийж), төхөөрөмжийг үйлдвэрийн анхны төлөвт нь оруулж болно.

## 1. Арын Гэрэл Backlight



Шөнө эсвэл өдрийн цагаар илүү сайн харахын тулд дэлгэцийн гэрлийг тохируулна

АНХААР! Арын гэрэлтүүлэг нь 10 түвшинтэй бөгөөд анхдагч тохиргоо нь 3 байна.

### Бара гэрэлтэлт Зайг хэмнэнэ Low brightness: Saves battery

Тод гэрэлтэлт: Дэлгэцийг гэрэл гэгээтэй орчинд илүү сайн харагдахад тусална.

### Арын гэрлийг хэрхэн тохируулах вэ? Backlight

Баруун эсвэл зүүн шилжих товчлуурыг ашиглан Мэргэжлийн цэсний тохиргооны цэс рүү шилжиж, сонгох товчийг ашиглан тохиргооны цэс рүү орно.



Баруун, зүүн сумаар Арын гэрлийн сонголт руу очно. Дээш, доош шилжих сүм товчоор арын гэрлийн түвшинг нэг шатаар нэмж эсвэл бууруулна. Сонгосон арын гэрлийн утга дэлгэцийн баруун талд гарч ирнэ.




**Цаг хэмжигчийн автомат унтраалгын тохиргоо Timer**  
Сонгох (Select) товчоор Цаг хэмжигчийн автоматаар унтрах хугацааг тохируулна. Сонгох товчийг дарж арын гэрлийн (backlight) автомат унтрах хугацааг дарааллуулан солих боломжтой: **үргэлж асаалттай (always on), 5 секунд, 10 секунд, болон 20 секунд** гэсэн сонголтуудаас идэвхжүүлснээр дэлгэцийн гэрэл сонгосон хугацааны дараа автоматаар унтрах болно.

АНХААР! Хэрэв та тогтсон хугацаанд ямар ч товчлуур дарахгүй бол арын гэрэл автоматаар унтарна.

5 секунд



10 секунд



20 секунд



## 2. Блютуз Bluetooth®



MAGNETAR 9000 нь таны чихэвчтэй Bluetooth®-ээр холбогдож, утасгүйгээр дуу авигаа сонсох боломжийг олгоно.

Чихэвчээ хялбархан холбохын тулд доорх үйлдлийг хий.

**MAGNETAR 9000-ийг Bluetooth® чихэвчтэй хэрхэн холбох (Pair) вэ?**

Баруун эсвэл зүүн навигацийн (сүмтай) товчлуурыг ашиглан тохиргооны цэс дэх Bluetooth® цонх руу шилжинэ. Сонгох (Select) товчийг дарж Bluetooth® цэс рүү орно.



Bluetooth® унтарсан байвал Сонгох (Select) товчийг дарж асаана. Bluetooth® идэвхжсэний дараа хэдэн секунд хүлээнэ. MAGNETAR 9000 ойр буй Bluetooth® чихэвчүүдийг хайж (сканердаж), жагсаалтаар харуулах болно.




АНХААР! Энэ үед чихэвч тань асаалттай болон хослуулах горимд байгаа эсэхийг шалгаарай.



Холбохыг хүссэн чихэвчээ жагсаалтаас дээш эсвэл доош шилжих товчлуураар сонгоно. Сонгох товчийг /select/ ашиглан сонголтоо баталгаажуулна.



Сонгосон чихэвч тань дэлгэц дээрх Холбогдсон (Paired) хэсэгт харагдах болно. Чихэвч амжилттай холбогдох үед дэлгэц дээр Bluetooth® болон чанга яригчийн дүрт тэмдэгтүүд (icon) харагдана.



Өмнө нь хослуулсан /paired/ чихэвч жагсаалтад харагдахгүй бөгөөд автоматаар холбогдоно.

АНХААР! Хэрэв таны чихэвч жагсаалтад харагдахгүй байвал хослуулах горимд байгаа эсэхийг шалгаарай.

✶ Стандарт Bluetooth® чихэвч холбогдсон.

✶ aptX™ бага хоцролттой чихэвч холбогдсон.

Bluetooth® чихэвч холбогдсон үед дээрх дүрт тэмдгээс нэгийг нь сонговол дуу авиан гаралт зөвхөн Bluetooth® чихэвчээр дамжиж сонсогдох болно.

ЧУХАЛ! Илүү сайн дууны сонсолт авахын тулд чихэвч чинь хугацааны хоцрогдол маш бага LL (LoW Latency) функцийг дэмждэг эсэхийг шалгаарай.

АНХААР! Чихэвч холбогдох үед дуу авиан гаралт автоматаар чихэвч рүү шилжинэ. Хэрэв хүсвэл та чанга яригчийг (speaker) давхар идэвхжүүлэх боломжтой.

Bluetooth® чихэвч холбогдсон үед чанга яригчийг хэрхэн идэвхжүүлэх вэ?

Дээш шилжих товчоор дэлгэцийн дээд хэсэгт байрлах дүрт тэмдэг рүү шилжиж, баруун сум товчоор Bluetooth® болон чанга яригчийн дүрт тэмдэгт бүхий хэсэг рүү шилжинэ. Сонгох (Select) товчийг дарж чанга яригчийг "Унтарсан" (Off)-аас "Ассан" (On) төлөвт оруулна.




Хэрэв та хадгалсан аливаа төхөөрөмжийн жагсаалтыг арилгахыг хүсвэл дээш эсвэл доош шилжих товчийг ашиглан хогийн савны дүрсийг сонгоод, сонгох товчийг дарж баталгаажуулж хэдэн секунд хүлээнэ үү.



АНХААР! Мөн Bluetooth® унтарсан байх үед хогийн савны дүрт тэмдэгт (икон) болон Сонгох (Select) товчийг ашиглан холбогдсон чихэвчүүдийг салгаж (жагсаалтаас хасах) болно.

Хэрэв Bluetooth® холболтод ямар нэгэн асуудал гарвал MAGNETAR 9000-ийн Bluetooth® тохиргоо болон чихэвчээ хоёуланг нь унтраагаад буцаан асааж туршина уу.

АНХААР! Та холбогдсон чихэвчийн дүрсийг дэлгэцийн баруун талд харж болно.



### 3. ЦЭСНИЙ ӨНГӨ Menu Colors



Та MAGNETAR 9000 -ийн дэлгэцийн харагдах байдлыг хэрэглээний нөхцөлдөө тохируулан өөрчилж болно. Гэрэлтүүлгийн нөхцөлд хамгийн тохиромжтойг нь олохын тулд 3 өөр өнгөний загвараас сонгоорой.

**Өдрийн цагаар ашиглах:** Нарны хурц гэрэлд зарим өнгө дэлгэц дээр мүү харагдах магадлалтай.

**Шөнийн цагаар ашиглах:** Харанхуйд зарим сэдэв харахад хэцүү байж магадгүй.

Тиймээс хамгийн сайн харагдах байдлыг хангахын тулд орчиндоо тохирсон цэсний өнгийг сонгоорой.

#### Цэсний өнгийг Хэрхэн Өөрчлөх вэ? Menu Colors

Баруун, зүүн шилжих товчлуурыг ашиглан тохиргооны цэсний Өнгөний цэсний сонголт руу очно. Ашиглахыг хүссэн цэсний өнгийг сонгоно. Дээш, доош шилжих товчлуураар сонгох товчийг дарж баталгаажуулна. Сонгосон цэсний өнгө дэлгэцийн баруун талд гарна.



АНХААР! Хэрэв Та сонгох товчийг даралгүй гарвал Сонгосон хэл хадгалагдахгүй, ашиглагдахгүй.

### 4. ХЭЛ Language



MAGNETAR 9000 нь хэрэглэгчдэд уян хатан хэрэглээг хангах 10 өөр хэлний сонголтыг санал болгодог.

АНХААР! Хайгчийг анх асаахад үйлдвэрийн тохиргоонд тохируулсан хэлээр эхэлнэ. Та хэлний тохиргоог хүссэн үедээ өөрчилж болно.

#### Хэлийг хэрхэн солих вэ? How to Change Language

Баруун эсвэл зүүн навигацийн товчлууруудыг ашиглан тохиргооны цэсний Хэлний сонголт руу очно. Дээш эсвэл доош навигацийн товчлууруудыг ашиглан ашиглахыг хүссэн хэлээ сонгоно уу. Сонгосон хэл дэлгэцийн баруун талд гарч ирнэ.



## 5. ТОВЧЛУУРЫН ДУУ Key Sounds



MAGNETAR 9000-ийн товчлууруудыг дарахад гарах "бип" (дуу) нь таны хэрэглээг хялбарчлах хариу дохиог өгдөг. Энэхүү дуу нь ялангуяа бээлийтэй байхдаа эсвэл харанхуй орчинд товчлуурыг санамсаргүй эсрэг дарахаас сэргийлэхэд маш тустай.

### Товчлуурын дууг хэрхэн өөрчлөх вэ? Key Sounds

Баруун, зүүн шилжих товчоор тохиргооны цэснээс Товчлуурын Дууны сонголт руу очно. Дээш эсвэл доош шилжих товчлуураар ашиглахыг хүссэн Товчлуурын Дууны сонголтыг сонгоно. Сонгосон Товчлуурын Дууны тохиргоо дэлгэцийн баруун талд гарч ирнэ.



### Товчлуурын дуу асах, унтрах on and off.



Товчлуур дуугарна On



Товчлуур дууграхгүй Off

## 6. ТОВЧЛУУРЫН ЧИЧИРГЭЭ Key Vibration



MAGNETAR 9000 товчлуурыг дарах үед чичиргээний хариу үйлдэл хүлээн авах боломжтой. Энэ функц нь товчлуур бүрийг дарж байгааг мэдрэх боломжийг олгосноор таны хэрэглээг хөнгөвчилнө. Энэ нь бээлий өмссөн эсвэл харанхуй орчинд санамсаргүй товчлуур дарахаас урьдчилан сэргийлэхэд онцгой тустай.

### Товчлуурын чичиргээг хэрхэн өөрчлөх вэ? Key Vibration

Баруун, зүүн шилжих товчлуурыг ашиглан тохиргооны цэсний Түлхүүрийн чичиргээ сонголт руу очно. Дээш, доош сум товчоор ашиглахыг хүссэн товчлуурын чичиргээний сонголтыг хийнэ. Сонгосон товчлуурын чичиргээний тохиргоо дэлгэцийн баруун талд гарч ирнэ.



### Товчлуурын дуу асах, унтрах on and off:



Товчлуур чичирнэ On



Товчлуур чичрэхгүй Off

## 7. Товчлуурын дуу Key Backlight



Товчлуурын арын гэрэлтүүлэг нь харанхуй орчинд товчлуурыг харахад илүү хялбар болгодог үйлдэл юм. Энэ нь шөнийн цагаар эсвэл гэрэл багатай орчинд харах байдлыг сайжруулснаар товчлуурыг амархан олох, ажиллахад тухтай нөхцлийг бий болгоно.

Товчлуурын гэрэлтүүлгийн түвшин нь дэлгэцийн гэрлийн түвшинд автоматаар зохицоно.

### Товчлуурын арын гэрэлтүүлгийг хэрхэн өөрчлөх вэ?

Баруун эсвэл зүүн навигацийн (сумтай) товчлуурыг ашиглан тохиргооны цэс дэх **Key Backlight** (Товчлуурын арын гэрэл) сонголт руу шилжинэ. Дээшээ эсвэл доошоо шилжих товчоор ашиглахыг хүссэн товчлуурын арын гэрэлтүүлгийн сонголтоо сонгоно. Сонгосон товчлуурын арын гэрэлтүүлгийн тохиргоо дэлгэцийн баруун талд харагдах болно.



### Товчлуурын гэрэл асах, унтрах on and off:



Товчлуурын гэрэл ассан On



Товчлуурын гэрэл унтарсан Off

## 8. Чийдэн Flashlight



Чийдэнг асааснаар харанхуй эсвэл гэрэл багатай орчинд Хайлтын таваг болон хайлт хийж буй газрыг гэрэлтүүлэхэд ашигладаг үйлдэл. Энэ нь шөнийн цагт хайлтын үеэр зорилтот хэсгийг илүү тод харах боломжийг танд олгоно. Энэ нь байг ухах үйл явцыг илүү хялбар, үр ашигтай болгодог.

### Чийдэнгийн гэрлийг хэрхэн өөрчлөх вэ? Flashlight

Баруун эсвэл зүүн навигацийн товчлууруудыг ашиглан тохиргооны цэснээс **Чийдэн /Flashlight/** сонголт руу очно. Дээш эсвэл доош навигацийн товчлууруудыг ашиглан ашиглахыг хүссэн Чийдэн сонголтоо сонгоно. Сонгосон Чийдэн тохиргоо дэлгэцийн баруун талд гарч ирнэ.



### Чийдэн асах, унтрах on and off:



Чийдэн ассан On



Чийдэн унтарсан Off

## 9. Хайгчийн мэдээлэл Device Info



MAGNETAR 9000 нь тохиргооны мэдээлэл, бодит цагийн ажилласан хугацаа болон нийт ажилласан хугацааг санах ойдоо хадгалж, хэрэглэгчид хэрэглээний давтагдашгүй боломж олгох үүднээс энэхүү мэдээллээ хуваалцдаг.

Асаасан агшнаас эхлэн хэр хугацаанд ажиллаж байгааг тэмдэглэдэг. Та ажилласан хугацааг Жил/Сар/Өдөр/Цаг гэсэн төлөвөөр харах боломжтой.

Та төхөөрөмжийнхөө програм хангамжийн хувилбарын дугаарыг **Device Info** (Төхөөрөмжийн мэдээлэл) хэсгээс харах боломжтой.

### Ажилласан хугацаа болон төхөөрөмжийн мэдээллийг хэрхэн харах вэ?

Баруун эсвэл зүүн навигацийн (сумтай) товчлуурыг ашиглан тохиргооны цэс дэх Device Info (Төхөөрөмжийн мэдээлэл) сонголт руу шилжинэ үү. Дээшээ эсвэл доошоо навигацийн товчлуураар харахыг хүссэн мэдээллээ сонгоно үү. Сонгосон мэдээлэл дэлгэцийн баруун талд харагдах болно.



## 10. Үйлдвэрийн тохиргоо Factory Reset



Энэ сонголт хайгчийг үйлдвэрийн тохиргоонд сэргээж, бүх хувийн тохиргоог дахин тохируулж, хадгалсан өгөгдлийг устгана. Дараах бүх тохиргоо үйлдвэрийн анхдагч утгадаа сэргэнэ:



Горим Mode



Хөрс Ground



Шуугиан дарах Noise Cancel



Газар тэнцвэржүүлэх G/balance



Мэдрэмж Sensitivity



Дууны хүч Volume



Суурь дууны хүч Threshold volume



Үелзлийн дууны хүч Threshold/F



Дууны Шүүлт Audio filter



Тогтворжуулагч Stabilizer



Байны дууны хүч Target Volume



Арын гэрэл Backlight



Бluetooth Bluetooth®



Цэсний өнгө Menu Colors



Товчлуурын дуу Key Sounds



Товчны чичиргээ Key Vibration



Арын гэрлийн товч Key Backlight



Чийдэн Flashlight

**Үйлдвэрийн тохиргоог хэрхэн сэргээх вэ?**

Баруун, зүүн шилжих товчоор тохиргооны цэснээс Үйлдвэрийн тохиргоо сонголт руу очно. MAGNETAR 9000-г үйлдвэрийн тохиргоонд нь оруулахын тулд сонгох /select/ товчийг 3 секундын турш дарна.

**ПРОГРАММЫН ШИНЭЧЛЭЛ**

1. Шинэчлэлийг эхлүүлэхэд хайгчийн зай дор хаяж 50% цэнэгтэй байх ёстой.
2. USB кабелийн нэг үзүүрийг хайгч төхөөрөмжид, нөгөө үзүүрийг компьютерт холбоно.
3. Төхөөрөмжийн дэлгэц дээр түгжих дүрс гарч ирнэ. Төхөөрөмж таны компьютер дээр MAGNETAR нэртэй зөөврийн USB диск хэлбэрээр гарч ирнэ.
4. Nokta вэбсайтаас шинэчлэлтийн файлыг (.zip) татаж авна. .hex файлыг zip хавтаснаас гаргаж авна. .hex файлыг MAGNETAR диск рүү хуулна. Файлын нэрийг бүү өөрчил.
5. Файлыг хуулж дууссаны дараа USB кабелийг компьютерээс салга. Шинэчлэлт автоматаар эхлэх болно.
6. Шинэчлэлт дуусахад төхөөрөмж өөрөө унтрах болно. Энэ процессын явцад батерейг нь салгаж болохгүй..

**АНХААР!** Шинэчлэлтийн явцад хайлтын таваг төхөөрөмжид холбогдсон эсэхийг шалгаарай.

**АНХААР!** .zip файлыг шууд хуулж болохгүй. Зөвхөн гаргаж авсан .hex файл л ажиллана.

**АНХААР!** Хэрэв та тохирохгүй файл байршуулбал кабелийг салгаад л болоо. Төхөөрөмж одоо буй software хувилбартайгаа ажилласаар байх болно..

**АНХААР!** Та мөн ямар ч файл татаж суулгахгүйгээр кабелийг салгаж болно. Төхөөрөмж хэвийн дэлгэц рүүгээ буцна.

**АЛДААНЫ КОД ERROR CODES**

Доорх мессежийн аль нэг дэлгэц дээр гарч ирсний дараа төхөөрөмж төдөлгүй унтардаг:



Error Code: 001

**001:** Системийн алдааг илтгэнэ. Төхөөрөмж автоматаар унтрах болно. Эрх бүхий Nokta үйлчилгээний төвтэй холбогдоно уу.



Error Code: 002

**002:** Гэмтсэн файл ачаалагдсан эсвэл программ хангамжийн шинэчлэлтийг дуусгаж чадаагүйг илтгэнэ. Төхөөрөмжийг компьютертэй холбож, NOKTA-гийн албан ёсны файлыг ашиглан шинэчлэлийг дахин эхлүүл. Олон оролдлоод бүтэхгүй бол NOKTA-гийн Төвд хандана уу.



Error Code: 003

**003:** Системийн алдааг илтгэнэ. Төхөөрөмж автоматаар унтрах болно. Эрх бүхий Nokta үйлчилгээтэй холбогдоно уу.



No Coil Detected!

Таваг холбогдсонгүй! Хайлтын тавгийг төхөөрөмж илрүүлж чадаагүйг илтгэнэ. Төхөөрөмж автоматаар унтрах болно. Тавагний холболтыг шалга. Хэрэв асуудал арилахгүй бол Nokta үйлчилгээний төвтэй холбогдоно уу.

**FO80** - Системийн алдаа. NOKTA төвтэй холбогдоно уу.

**АНХААРУУЛГА МЕССЕЖ**

Overload!

**Хэт ачаалал!** Хайлтын таваг хэт ачаалалтай байгааг илтгэнэ. Энэ анхааруулга гарч байх үед төхөөрөмж байг илрүүлж чадахгүй.

Хайлтын ороомгийг том металл эд зүйлсээс хол байрлуулахад анхааруулга автоматаар алга болно.



Low Battery!

**Зай дундарсан!** Зайны цэнэг бага байгааг илтгэнэ. Төхөөрөмжөө цэнэглээрэй.



Low Battery.  
Cannot Update!

**Зай сул байна!** Шинэчилж чадахгүй байна: Зайний түвшин шинэчлэл хийхэд хэт бага байна. Шинэчлэлт хийхээсээ өмнө төхөөрөмжөө цэнэглэнэ уу.



## СЭРГЭЭХ RECOVERY



Шинэчлэх явцад зайг бүү салга! Зай тасалдвал төхөөрөмж автоматаар сэргээх /**recovery**/ горимд орно. Энэ мессеж дэлгэц дээр гарч ирнэ. Төхөөрөмжийг унтрааж болохгүй, эсвэл цэнэглэгчийг салгаж болохгүй. сэргээх үйл явц дуусахыг хүлээнэ үү.

Тэвчээртэй хүлээх: Төхөөрөмж өөрийгөө сэргээж, системийг засах ажиллагааг дуустал хүлээх хэрэгтэй.

Тэжээлд холбох: Хэрэв боломжтой бол цэнэг дуусахаас сэргийлж цэнэглэгчид залгаастай чигээр нь байлгана.



Шинэчлэл амжилтгүй – Дахин эхлүүл: Хэрэв сэргээх үйл явцыг 180 секундын дотор дуусгаж чадахгүй бол энэ мессеж гарч ирнэ.

Төхөөрөмжийг унтраахын тулд асаах товчийг 10 секундын турш дарна. Дараа нь буцааж асаана; сэргээх үйл явц автоматаар дахин эхэлнэ. Хэрэв олон оролдлогын дараа асуудал арилахгүй бол эрх бүхий Nokta үйлчилгээний төвтэй холбогдоно үү.

## ЧИХЭВЧНИЙ МЭДЭЭЛЭЛ

MAGNETAR 9000 нь Bluetooth® чихэвчтэй ирдэг. Bluetooth® чихэвч нь ус нэвтэрдэггүй, усанд норгож болохгүй.

Төхөөрөмжийн системийн бие усанд дүрэгдээгүй байх үед Bluetooth® холболт хэвийн ажиллана. Өөрөөр хэлбэл, хайлтын таваг (**Search Coil**) усан дотор байх үед гүехэн усанд хайгуул хийхдээ утасгүй чихэвч ашиглах боломжтой. Гэсэн хэдий ч утасгүй чихэвчийг усанд хүргэж болохгүй гэдгийг санаарай.

Хайгчийг бүхэлд нь усанд дүрэх үед утасгүй холболт /**Bluetooth®**/ ажиллахгүй. Энэ тохиолдолд та хуурай газар болон усан дотор аль алинд нь ашиглах боломжтой, нэмэлтээр зардаг "Nokta" усны хамгаалалттай чихэвчийг авч ашиглах шаардлагатай. Хэрэв та зөвхөн хайгчийн биеийг усанд дүрээд, чихэвчийг усанд дүрэхгүй бол усны хамгаалалттай холбогчтой "Nokta Koss" чихэвчийг сонгох боломжтой.

Хуурай газарт ашиглах үед хэрэв та MAGNETAR 9000-ийг өөрийн утастай чихэвчтэй ашиглахыг хүсвэл нэмэлтээр зардаг чихэвчний адаптерийг худалдаж авах хэрэгтэй.

## ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ TECHNICAL SPECIFICATIONS

|                                                          |                                                                                                                               |
|----------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Ажиллах зарчим:                                          | Дэвшилтэт цохилтот өдөөлт - импульсийн индукц                                                                                 |
| Горим:                                                   | Хамгийн дээд / Стандарт / Гүн                                                                                                 |
| Хөрс:                                                    | Ердийн / Хүнд / Хэт эрдэсжилтэй                                                                                               |
| Газар тэнцвэржүүлэлт                                     | Автомат / Хагас автомат / Гар ажиллагаатай                                                                                    |
| Үйлдлийн цэс:                                            | Хялбар ба мэргэжлийн                                                                                                          |
| Хайлтын Таваг                                            |                                                                                                                               |
| MAGNETAR 9000:                                           | MG37-DRC 14.5" x 13" / 37 см x 34 см                                                                                          |
| MAGNETAR 9000:                                           | MG29-DRC 11" / 29 см x 21 см                                                                                                  |
| Аудио дууны:                                             | Чанга яригч, Bluetooth® болон 1/4" (6.3 мм) чихэвчний залгуур                                                                 |
| Дэлгэц:                                                  | Бүрэн өнгөт, 320 x 240 пиксел, 49мм x 37мм (1.9" x 1.5")                                                                      |
| Урт:                                                     | 150см (59") – 72см (28") эвхэгддэг                                                                                            |
| Жин:                                                     | 5.3 фунт / 2.4 кг (11 инчийн хайлтын таваг болон зайны хамт),<br>6.2 фунт / 2.8 кг (14 инчийн хайлтын таваг болон зайны хамт) |
| Ажиллах температурын хүрээ:                              | 32°F - 122°F (0°C to 50°C)                                                                                                    |
| Ажиллах чийгшлийн хүрээ:                                 | 95% хүртэл конденсацгүй/ууршилгүй                                                                                             |
| Хадгалах температурын хүрээ:                             | -4°F - 140°F (-20°C - 60°C)                                                                                                   |
| Усны хамгаалалтын үнэлгээ:                               | IP68, 10 фут (3 метр) хүртэл                                                                                                  |
| Баталгаат хугацаа:                                       | 3 жил                                                                                                                         |
| Хэрэглэгчийн өөрчлөн тохируулсан тохиргооны профайл сан: | Тийм                                                                                                                          |
| Тохируулж болох босго дууны хэмжээ:                      | Тийм                                                                                                                          |
| Тохируулж болох суурь дууны давтамж:                     | Тийм                                                                                                                          |
| Шуугиан дарах:                                           | Тийм                                                                                                                          |
| Товчлуурын чичиргээ:                                     | Тийм                                                                                                                          |
| Товчлуурын дуу:                                          | Тийм                                                                                                                          |
| Товчлуурын арын гэрэл:                                   | Тийм                                                                                                                          |
| Мэдрэмжийн тохиргоо:                                     | 20 түвшин/шатлал                                                                                                              |
| Дэлгэц:                                                  | Өнгөт LCD                                                                                                                     |
| Арын гэрэлт:                                             | Тийм                                                                                                                          |
| Чийдэн:                                                  | Тийм                                                                                                                          |
| Зайны Техникийн үзүүлэлт:                                |                                                                                                                               |
| Төрөл хэлбэр:                                            | Цэнэглэж болох Лити-ион зай                                                                                                   |
| Лити-ион зайны гаралтын хүчдэл                           | 7.2V DC                                                                                                                       |
| Лити-ион зайны багтаамж:                                 | 48Wh                                                                                                                          |
| Ажиллах Хугацаа:                                         | 7-10 цаг                                                                                                                      |

## ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ TECHNICAL SPECIFICATIONS

|                           |                              |
|---------------------------|------------------------------|
| Лити-ион батерейны жин:   | 270 gr (9.6oz)               |
| Зай ажиллах температур:   | 32°F to 122°F (0°C to 50°C)  |
| Зайг хадгалах температур: | 23°F to 158°F (-5°C to 70°C) |

Цэнэглэгчийн техникийн үзүүлэлт:

|                          |                                |
|--------------------------|--------------------------------|
| Ажиллах температур:      | 32°F to 113°F (0°C to 45°C)    |
| Хадгалах температур/хэм: | -22°F to 176°F (-30°C to 80°C) |
| Оролтын хүчдэл:          | 12 to 30 VDC                   |
| USB гаралтын гүйдэл:     | 500 mA/MA                      |

*Bluetooth®* брэнд болон лого нь *Bluetooth® SIG, Inc.* компаний эзэмшдэг бүртгэлтэй худалдааны тэмдэгтүүд юм.  
*Qualcomm® aptX™* нь *Qualcomm Technologies, Inc.* компаний бүтээгдэхүүн болно.  
*Nokta Detectors* компани нь бүтээгдэхүүний үзүүлэлт, загвар болон дагалдах хэрэгслийг хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдэлгүй өөрчлөх эрхтэй.



Европын Холбооны хэрэглэгчдэд анхааруулах нь: Энэ төхөөрөмжийг ахуйн хог хаягдал руу хаяж болохгүй. Энэхүү төхөөрөмж дээрх дугуйтай хогийн савны тэмдэг нь уг төхөөрөмжийг ахуйн хог хаягдал руу хаяж болохгүй, харин орон нутгийн засаг захиргааны дүрэм журам, байгаль орчны шаардлагын дагуу дахин боловсруулж болохыг илтгэнэ.



FCC – ХАРИЛЦАА ХОЛБООНЫ КОМИССЫН МЭДЭГДЭЛ  
Энэ төхөөрөмж нь FCC-ийн дүрмийн 15-р хэсгийг дагаж мөрдөнө. Ашиглалт нь дараах хоёр нөхцөлөөс хамаарна: (1) энэ төхөөрөмж хортой хөндлөнгийн нөлөө үүсгэхгүй. (2) Бусад төхөөрөмжөөс ирж буй жижиг радио долгионы саадыг таны төхөөрөмж даан ажиллах ёстой. Хэрэв ойролцоох өөр төхөөрөмжөөс болж бага зэргийн саатал гарвал энэ нь хайгчийг эвдэрсэнд тооцохгүй, хэвийн үзэгдэл гэж үзнэ.











